

# Хараат бус тайлагналын механизм

Үр дүнгийн тайлан:  
Монгол улс 2021–2023

---

Open  
Government  
Partnership



Independent  
Reporting  
Mechanism

## Гүйцэтгэлийн хураангуй

**Монгол улсын Нээлттэй засгийн түншлэлийн (НЗТ) Үйл ажиллагааны үндэсний 4 дүгээр төлөвлөгөө нь төрийн худалдан авах ажиллагаа болон төрийн үйлчилгээний талаарх хэрэгцээт өгөгдөл мэдээллийн хүртээмжийг ханган өгөхийн зэрэгцээ мэдээллийн хүртээмж, эрх чөлөөний талаарх хууль тогтоомжуудыг улам сайжруулах боломжийг нээн гаргасан. НЗТ-ийн үндэсний платформ нь иргэний нийгэм болон төрийн үүрэг хүлээгч талуудад хязгаарлагдмал байдлаар хяналт, зохицуулалт хийх боломжийг бүрдүүлсэн ч хэрэгжилтийн хугацааны сүүлийн 6 сард үүнд гарсан алдаа дутагдлыг засан залруулах чиглэлд ажиллах болжээ. Үүрэг амлалтуудыг Засгийн газар өөриймшүүлэн хэрэгжүүлэх, иргэний нийгэмтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг хангаснаар Монгол улс нь НЗТ-ийн үйл явцаас илүү бодит үр дүнг цаашид гаргах боломжтой.**

### Урьдчилсан үр дүн

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 9 үүрэг амлалтаас 3 дээр нь урьдчилсан байдлаар үр дүнгүүд гарсан ба үндсэндээ төрийн мэдээллийн хүртээмжийг хангах чиглэлээр үр дүн түлхүү гарсан байна. Үүрэг амлалт 3 дээр төрийн худалдан авах ажиллагааг нэгтгэсэн, онлайн тендерийн порталыг сайжруулсан, тендерийн мэдээллийн нээлттэй өгөгдлийн порталыг нээн ажиллуулсан зэрэг өмнөх үйл ажиллагааны төлөвлөгөөний үр дүн дээр суурилан ихээхэн амжилт гаргажээ. Мөн хоёр үүрэг амлалт дээр мэдээллийн хүртээмж, ил тод байдлын хууль тогтоомжуудыг сайжруулж (Үүрэг амлалт 2), E-Mongolia болон шинээр эхлүүлсэн E-Business платформууд дээр төрийн үйлчилгээний талаарх практик мэдээллийг нээлттэй болгожээ (Үүрэг амлалт 9). Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бусад зургаан үүрэг амлалт нь ил харагдахуйц томоохон үр дүнг гаргаагүй, хэрэгжилтийн явцад саад тотгорууд тулгарч ирсэн ба ХБТМ-ын зүгээс анхны төлөвлөлтийн шатанд хамгийн өндөр үр дүн гаргах боломжтой хэмээн тодорхойлсон таван үүрэг амлалтын гурав нь эдгээрт багтжээ. Нийтэд нь авч үзвэл энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө нь төрийг ил тод нээлттэй болгох чиглэлээр багахан хэмжээнд ахиц гаргасан өмнөх төлөвлөгөөтэй харьцуулбал илүү сайн үр дүнг гаргажээ.

### Хэрэгжилтийн явц/ бүрэн хэрэгжсэн байдал

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 9 үүрэг амлалтын 4 нь (44%) тодорхой хэмжээнд болон бүрэн хэмжээнд (2, 3, 6 болон 9) биелэгдэж, эдгээрийн ихэнх нь төрийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр эрт үеийн/ урьдчилсан үр дүнг гаргаад байна. Нийт 13 үүрэг амлалтаас 4 нь (31%) тодорхой хэмжээнд болон бүрэн хэрэгжиж байсан өмнөх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулж үзвэл энэ нь арай илүү өндөр хэмжээнд хэрэгжсэн байна. Монголын НЗТ-ийн платформын хяналт, зохицуулалт хомс буй нөхцөлд ч ахиц

## ХЭРЭГЖИЛТИЙН ТОЙМ

### Хэрэгжилтийн түвшин

4/9

Иж бүрэн эсвэл өндөр хэмжээнд хэрэгжсэн үүрэг амлалтууд

### Эрт үеийн үр дүн

3/9

Эрт үеийн үр дүн гаргасан үүрэг амлалтууд

1/9

Тодорхой хэмжээний үр дүн гаргасан үүрэг амлалтууд

### МИНИМУМ ШААРДЛАГЫГ ДАГАН МӨРДСӨН ЭСЭХ

НЗТ-ийн үйл явцын дагуу явагдсан.

дэвшил гараад буй үүрэг амлалтууд нь Засгийн газрын зүгээс тодорхойлсон тэргүүлэх чиглэлүүдэд мөн тусгагдсан байна. Гэвч эдгээр санаачилгууд НЗТ-ийн үүрэг амлалтуудад багтсан буй хэрэгжилтийг үргэлжлүүлэн явуулах гол түлхэц болсонгүй. Жишээ нь үүрэг амлалт 6 нь одоо хэрэгжиж буй Дэлхийн банкны төслийн зорилготой ижил буй тул хэрэгжилт үргэлжлэн явагджээ. Үүрэг амлалт 2 болон 3 нь улсын хэмжээнд гарсан дуулиант хэргүүдийг дараа олон нийтийн зүгээс хүчтэй шаардах болсноос үүдэн Засгийн газрын зүгээс авлигатай тэмцэх арга хэмжээнд илүү өндөржүүлсэн байдлаар анхаарал хандуулах болсонтой холбоотойгоор өргөн хүрээнд хэрэгжжээ. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бусад үүрэг амлалт нь тодорхой сорилтуудтай тулгарсны тоонд хамаарах талууд ихээр өөрчлөгдсөн, цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөө, геополитикийн хямрал зэрэг багтаж байна. Иргэний нийгмийн оролцоо буурсан нь үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц эх үүсвэр, дэмжлэгт хийдэл үүсгэсэн. Иргэний орон зай, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах чиглэлийн үүрэг амлалтууд (4 болон 8) дээр томоохон ахиц гараагүй нь Монгол улсын хувьд эдгээр шинэчлэлийг хийх чиглэлээрх нээлттэй засгийн үйл явцыг үргэлжлүүлэх цаашдын хэрэгцээг бий болгож байна.

### **Оролцоо, хамтран боловсруулах үйл явц**

Өмнөх үйл ажиллагааны хоёр төлөвлөгөөний хувьд НЗТ-ийн үйл явцыг зөрчиж байсан хэмээн тооцогдож байсан бол энэ удаад хамтран боловсруулах болон хэрэгжүүлэх шатанд Монгол улс нь НЗТ-ийн оролцооны босго шаардлагыг хангасан. Хамтран боловсруулах үйл явц нь оролцооны үйл явцтай харьцуулбал бага зэрэг сайжирсан ба үүнд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад иргэдийн өгсөн саналуудыг хэрхэн тусгасан тухай үндэслэл бүхий хариулт гарган өгсөн нь эергээр нөлөөлжээ. Хэрэгжилтийн ихэнх хугацаанд үүрэг амлалтууд дээр гарч буй ахиц, үйл ажиллагааны төлөвлөгөөний бүхий л шатан дахь оролцоо дээр ямар нэгэн хяналт хийгдээгүй, Монгол улсын НЗТ-ийн платформын хүрээнд Засгийн газар болон иргэний нийгмийн оролцогч талууд хооронд ямар нэгэн зохицуулалт хийгдээгүй. НЗТ-ийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг ролийг ЗГХЭГ-аас Эдийн засаг, хөгжлийн яаманд, улмаар ЗГХЭГ-ийн харьяанд ажилладаг ХЭҮК-т шилжүүлсэн. Засгийн газраас үүрэг амлалтуудыг УУХҮЯ, БОАЖЯ мөн ЦХХХЯ-нд тараан хариуцуулсан яамд хэд хэдэн үүргийг тус тусдаа хариуцах болж, улмаар уялдаа зохицуулалтын чиглэлд хийдэл үүсгэжээ. Хэрэгжилтийн эхний 6 сарын хугацаанд ХЭҮК нь энэхүү хийдлийг засан залруулах арга хэмжээ авч эхэлсэн ба НЗТ-ийн Үндэсний зөвлөлд шинээр сонгогдсон гишүүд 2023 оны 7 болон 8 дугаар саруудад тус тус хуралдаж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайланг Монголын НЗТ-ийн мэдээллийг санд байршуулжээ.

### **Нөхцөл байдал дахь хэрэгжилт**

Засгийн газрын түвшинд хийгдсэн өөрчлөлтөөс гадна Монгол улсын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд геополитикийн болон дотоодын олон тооны сорилт тулгарсан. Далайд гарцгүй орны хувьд Монгол улс нь хөрш хоёр орон болох БНХАУ болон ОХУ-ын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай. БНХАУ-тай хийж буй худалдаа нь Монгол улсын нийт худалдааны 60%-ийг эзэлдэг.<sup>1</sup> БНХАУ нь Тэг КОВИД бодлого хэрэгжүүлж эхэлснээр өргөн хэрэглээний барааны хангалт тасарч, 2020 онд 1.9% байсан инфляц 2021 онд 3.5%, 2022 онд 8.3% болж өссөн.<sup>2</sup> Украйны дайнаас үүдэн Монгол улс нь мөн улс төрийн хараат бус байдлаа хадгалах, гадаад худалдаа, нефтийн бүтээгдэхүүний хамааралтай байдал хоорондын тэнцвэрээ хангах шаардлага үүссэн.<sup>3</sup> Түүнчлэн хэрэгжилтийн хугацааны төгсгөл үед КОВИД-19 цар тахлын хөл хорио суларсан ч үүнээс үүдсэн нөлөөллийн улмаас Засгийн

газар эдийн засгийн арга хэмжээгээ эрэмбэлэн хэрэгжүүлэх шаардлага гарч, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулан төсөв хөрөнгө хуваарилах боломжгүй болжээ. Мөн төр дэх авлигын улмаас олон нийтийн итгэл үргэлжлэн буурч иржээ. ТӨК-иуд дээр гарсан авлигын дуулиант хэргүүдийн улмаас 2022 оны эцсээр удаан хугацаанд үргэлжилсэн олон нийтийн эсэргүүцэл өрнөсөн. Үүнээс үүдэн авлигын эсрэг үйл ажиллагаанд түлхүү анхаарал хандуулах болсон ба үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа ч үүнд дэмжлэг болжээ. Иргэний нийгмийн орчин сорилттой үргэлжлүүлэн нүүр тулж, үүнийг CIVICUS байгууллагын зүгээс улам “хавчиг” болсон хэмээн тодорхойлж байна.<sup>4</sup>

---

<sup>1</sup> Antonio Graceffo, “Mongolia suffers under China’s zero-Covid policy,” The Lowy Institute, 19 January 2022, <https://www.lowyinstitute.org/the-interpretor/mongolia-suffers-under-china-s-zero-covid-policy>. (Хятадын Тэг-Ковид бодлого Монгол улсад сөргөөр нөлөөлж байна)

<sup>2</sup> “Inflation, consumer prices (annual %), Mongolia,” The World Bank, accessed 20 August 2023, <https://data.worldbank.org/indicator/FP.CPI.TOTL.ZG>. (Инфляц, өргөн хэрэглээний барааны үнэ- жилийн хувь- Монгол улс)

<sup>3</sup> David Stanway, Mongolia’s East-West balancing act buffeted by Russian invasion of Ukraine, Reuters, 3 March 2022, <https://www.reuters.com/world/asia-pacific/mongolias-east-west-balancing-act-buffeted-by-russian-invasion-ukraine-2022-03-03>. (Монгол улсын Өрнө- Дорнын тэнцвэрийг хангах үйл ажиллагаа ОХУ Украйныг эзлэн түрэмгийлснээс үүдэн саарч байна)

<sup>4</sup> CIVICUS, “People Power Under Attack 2023,” 2023, (Ард иргэдийн эрх халдлагад өртлөө) <https://civicusmonitor.contentfiles.net/media/documents/GlobalFindings2023.pdf>.

## Агуулга

Бүлэг I: Ажиглалтын үндсэн үр дүн .....	5
Бүлэг II: Хэрэгжилт, урьдчилсан үр дүн .....	7
Бүлэг III. Оролцоо, хамтран боловсруулах үйл явц.....	17
Бүлэг IV. Арга зүй, ХБТМ-ын шалгуурууд .....	21
Хавсралт I. Үүрэг амлалтуудад хамаарах өгөгдөл мэдээлэл.....	24

## Бүлэг I: Ажиглалтын үндсэн үр дүн

Энэ бүлэгт Монгол улсын Үндэсний 4 дүгээр төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд ажиглагдсан гурван гол үр дүнг тусган харуулсан. Эдгээр ажигласан үр дүн нь НЗТ-ийн үйл явц дахь манлайлал, Засгийн газрын өргөн хүрээний тэргүүлэх чиглэл нь үүрэг амлалтуудын хэрэгжилтэд нөлөөлж буй байдал болон үйл ажиллагааг иргэний нийгэмтэй уялдуулан зохицуулах байдал сул буй зэрэг асуудалд төвлөрсөн. Доор дурдсан буй ажиглагдсан үр дүнгүүд нь нийтлэг байдлаар Засгийн газар иргэний нийгэмтэй хамтран ажилласнаар НЗТ-ийн үйл явцын хүрээнд илүү бодитой үр дүнг цаашид хангах боломжтойг харуулж байна.

**Ажиглалтын үр дүн 1: НЗТ-ийн чиглэлээр бодит хамтын ажиллагаа нь Засгийн газар үүрэг амлалтуудын тогтвортойгоор өөриймшүүлж, төсөв хөрөнгийн хангалт сайтай олон талын оролцоот орчинд хамгийн үр дүнтэй өрнөж байна.** Хамтран боловсруулах үе шатны дараагаар НЗТ-ийг тэргүүлэн ажиллах байгууллагууд идэвх санаачилга сул байсан тул НЗТ-ийн платформ нь хэрэгжилтийн олон боломжоо алджээ. Үүний улмаас үүрэг амлалтын хэрэгжилтэд байнгын хяналт-шинжилгээ хийгдэлгүй орхигдож, төрийн байгууллагуудын удирдлага солигдсоноос үүдэн иргэний нийгмийн оролцоо хязгаарлагдаж иржээ. 2023 оны 3 дугаар сараас эхлэн тэргүүлэх байгууллага болсноор Хүний эрхийн үндэсний комисс нь энэхүү байдлыг засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж, Үйл ажиллагааны төлөвлөгөөний хугацаанд зохион байгуулагдсан Үндэсний зөвлөлийн цорын ганц хурлыг зохион байгуулж, хамаарах байгууллагуудаас хэрэгжилтийн тайланг гаргуулжээ. Гэхдээ энэхүү сайжирсан нөхцөл байдал нь хэрэгжилтийн сүүлийн саруудад л үүссэн байна. Дараагийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах үйл явц эхлэхээс өмнө ХЭҮК нь Монгол улс НЗТ-д нэгдэн орсноос хойш түншлэгч байж ирсэн иргэний нийгмийг төлөөлөх оролцогч талуудтай уулзалт зохион байгуулсан. Энэхүү үүссэн таатай мөчийг дараагийн хамтран төлөвлөх шатнаас гадна төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд ч тогтвортой хадгалан үлдээх нь чухал байна. Үүний тулд ХЭҮК болон НЗТ-ийн Үндэсний зөвлөлд хангалттай хэмжээний санхүүжилтийг улсын төсвөөс хуваарилах шаардлагатай ба санхүүжилт, чиг үүргийг тодорхой тусгасан эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар үүнийг хангах боломжтой. Түүнчлэн олон талын оролцоот үйл явц дахь манлайллын чиг үүргийг оролцооны тодорхой дүрэм, журмын хүрээнд төр болон иргэний нийгэм хуваалцаж болно.

**Ажиглалтын үр дүн 2: Засгийн газрын тэргүүлэх чиглэлд үүрэг амлалтууд өргөн хүрээнд тусгагдсан байх нь цаашдын хэрэгжилтийн явцыг тодорхойлж байна.** Үүрэг амлалтууд нь бүрэн хэмжээнд хэрэгжих байдлын хувьд тодорхой түвшинд хүрсэн, энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дунд хэмжээнд эрт үеийн үр дүнг гаргасан үүрэг амлалтууд нь бүгд Засгийн газрын зүгээс тодорхойлсон баримтлах тэргүүлэх чиглэл, үүнд хандсан үйл ажиллагаанд суурилан хэрэгжжээ. Жишээ нь Үүрэг амлалт 3 нь авлигын томоохон дуулиант хэрэг гарсны дараагаар олон нийтийн зүгээс хүчтэй шаардаж, Засгийн газрын зүгээс авлигатай тэмцэх үйл ажиллагаанд түлхүү анхаарал хандуулах болсноос үүдэн томоохон үр дүнг гаргажээ. Эсрэгээр Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд онцлон тусгагдаагүй үүрэг амлалтууд нь эрт үеийн үр дүнг гаргаагүй байна. Үүрэг амлалт 4 нь Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ дээр үр дүн гаргах боломжтой хэмээн үнэлэгдсэнээс бусдаар өөрийн төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй буй нь нэг талаар Засгийн газрын эс үйлдэл, нөгөө талаар ИНБ-ууд хууль ёсоор үйл ажиллагаа явуулахад саад тотгор нэмж магад хэмээн үзсэнээс иргэний нийгмийн зүгээс шахаж

шаардахгүй буйгаас үүджээ. Дээрхийн нэгэн адил Үүрэг амлалт 7 ч мөн Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд багтаагүй, хэрэгжилт нь хязгаарлагдмал хэмжээнд явагджээ.

**Ажиглалтын үр дүн 3: Олон нийтийн зүгээс тавьж буй шаардлага үр дүнг хангахад хувь нэмэр оруулж байна.** Монголын НЗТ-ийн платформ нь өөрийн хэрэгжилтийн хугацаанд үүссэн таатай цаг мөчийг ашиглаж чадаагүйн улмаас хэрэгжээгүй ихэнх үйл ажиллагаа нь иргэний нийгмийн идэвхтэй оролцоотойгоор хэрэгжих шаардлагатай үйл ажиллагаанууд байна. Жишээ нь Үүрэг амлалт 4 болон 5 дээр заасан хуулийн нэмэлт өөрчлөлт, бодлогын үнэлгээ нь иргэний нийгэм, олон нийтийн зүгээс дэмжлэг тодорхой хэмжээнд хомс буйгаас үүдэн бүрэн хэрэгжээгүй. Эхэн үеийн үр дүн сайн гарсан үүрэг амлалтуудын хувьд олон нийтийн зүгээс хүчтэй шахалт үзүүлж ирсэн нь Засгийн газар арга хэмжээ авахад түлхэц болжээ. Олон нийтийн сүлжээнд хяналт тавих агуулга бүхий хуулийг эсэргүүцсэн цахим өргөдөл олон нийтийн зүгээс гарган хуулийг цуцлахыг олон нийт дэмжсэнээр Ерөнхийлөгчийн зүгээс тухайн хуульд хориг тавьсан. Үүрэг амлалт 9-ийн хүрээнд E-Mongolia цахим платформын хэрэглэгчдийн тоо өссөн нь ЗГ-ын зүгээс тухайн платформын хүртээмжийг хангахын тулд илүү их хөрөнгө оруулалт хийхэд эерэг түлхэц болсон. Дараагийн Үйл ажиллагааны төлөвлөгөө нь энэхүү олон нийтийн өргөн хүрээний оролцоог зөвхөн иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөн санал авахаас гадна бодлого боловсруулах тодорхой алхмуудтай холбож өгснөөр үр дүнд хүрэх тодорхой үүрэг амлалтуудыг багтааж болно. Жишээ нь зохицуулалтын шинэчлэл хийхэд оролцогч талууд хичээж буй бол олон нийтээс дэмжлэг авч, шинэчлэл хийх шаардлага гаргуулах нь боломжит үр дүнг гаргахад дэмжлэг болж болно (онлайн өргөдөл, олон нийтийн нээлттэй зөвлөлдөх үйл явц зэрэг арга замыг ашиглан).

## Бүлэг II: Хэрэгжилт, урьдчилсан үр дүн

Доорх хэсэгт НЗТ-ийн зүгээс хэрэгжилтийн явцад хамгийн өндөр үр дүн гараад буй хэмээн үзэж буй гурван үүрэг амлалтыг тусган харуулсан. Урьдчилсан (цаашид эрт үеийн гэх) үр дүнг үнэлэхийн тулд Хараат бус тайлагналын механизм (ХБТМ) нь Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэрэгжихүйц хэмээн тодорхойлогдсон үүрэг амлалт/ багц үүрэг амлалтыг авч үзсэн. Тухайн үүрэг амлалтууд нь бүрэн хэрэгжиж буй эсэхийг баталгаажуулсны дараагаар Хараат бус тайлагналын механизм нь бүрэн хэрэгжихүйц хэмээн тогтоогдоогүй ч хэрэгжилтийн явцад томоохон үр дүн гаргаад буй үүрэг амлалтуудыг мөн судлан үзсэн.

### Үүрэг амлалт 2: Төрийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Хууль зүй, дотоод хэргийн яам

#### Нөхцөл байдал, зорилтууд

Төрийн байгууллагууд өөрийн үзэмжээр мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хүрээнд багтааж, нууцалж буй явдлыг хязгаарлах зорилго бүхий энэхүү амлалт нь Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд хэрэгжилтийн үнэлгээ хийж, нэмэлт өөрчлөлтийн төслийн боловсруулан, санал болгох үйл ажиллагааг багтаасан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт эхлэхээс өмнө 2020 онд Фрийдом Хаус болон Монгол улсын ИНБ Глоб Интернейшнл хамтран тухайн хуулийн хэрэгжилтэд буй асуудлыг гарган ирсэн ба үүнд мэдээлэл гарган өгөхөөс татгалзаж буй төрийн байгууллагууд нь ихэнх тохиолдолд Төрийн болон албаны нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан зарим заалтыг үндэслэл болгож буйг тогтоон гаргасан.<sup>1</sup> Төрийн мэдээллийн хүртээмжийг нээлттэй болгосноор энэхүү үүрэг амлалт нь олон нийтийн зүгээс засаглалд хяналт тавих, оролцох боломжийг, ялангуяа энэ чиглэлээрх АТГ-ын үйл ажиллагааг сайжруулахаар төлөвлөсөн.

#### Эрт үеийн үр дүн: Дунд хэмжээнд

Энэхүү үүрэг амлалт нь тодорхой бодит хэмжээнд хангагдсан. Үүний хүрээнд төлөвлөсөн хуулиудын гурван нэмэлт өөрчлөлтийг батлан гаргасан. Тухайн нэмэлт өөрчлөлтүүд нь төрийн мэдээллийг нээлттэй болгоход эрт үеийн үр дүнг дунд хэмжээнд гаргасан.

УИХ-аас 2022 оны 6 дугаар сард Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг батлан гаргасан.<sup>2</sup> Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр төрийн байгууллагуудын зүгээс нийтэд ил тод болгох үүрэг бүхий мэдээллийн ангилалд шинээр 68 шинэ ангиллыг багтаасан ба үүнд газрын хэвлийн баялаг, тусгай зөвшөөрөл, эцсийн өмчлөгч, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, ус ашиглалт болон Засгийн газрын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон тайлан, шинээр гаргахаар бэлтгэж буй журмуудын төсөл зэрэг олон төрлийн мэдээллийг ил тод болгож байхаар заажээ. Гэсэн энэхүү нэмэлт өөрчлөлтөөр хаалттай мэдээллийн талаарх 10 дугаар зүйлд буй “төрийн нууц” гэсэн ангиллыг ямар нэгэн байдлаар тодорхойлолгүй үлдээжээ. Үүний улмаас Төрийн болон албаны нууцын тухай хууль үргэлжлэн өмнөхийн адил хэрэгжиж буй ба үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн төгсгөл үед тухайн хуульд ямар нэгэн нэмэлт өөрчлөлт хийгдээгүй байна.



ХЭҮК-ын үзэж буйгаар Засгийн газар, төрийн байгууллагуудын боловсруулж буй журам, дүрмийн төслүүдийн ил тод байдал сайжирч буй нь иргэний оролцоог идэвхжүүлж буйг онлайн өргөдлийн [uih.mn/petition](http://uih.mn/petition) порталын үйл ажиллагаанаас харж болно. Хэдий энэхүү үйл ажиллагаа нь НЗТ-ийн үүрэг амлалтын хүрээнд багтаагүй ч Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, үүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтийн үр дүнг илтгэн харуулж байна.<sup>3</sup> Жишээ нь УИХ-ын зүгээс Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг батлах шийдвэрийг 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр гаргасны дараа тухайн хуулийн төсөл олон нийтэд нээлттэй болж, улмаар хуульд хориг тавихыг Ерөнхийлөгч У.Хүрэлсүхээс шаардсан өргөдөлд нийт 7,353 иргэн гарын үсэг зурсан байна.<sup>4</sup> Хил хязгааргүй сурвалжлагчид байгууллагын зүгээс энэхүү хуулийг “сэтгүүл зүй болон мэдээлэл авах олон нийтийн эрхэд аюул учруулж буй хууль” хэмээн үзжээ.<sup>5</sup> 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Ерөнхийлөгчийн зүгээс тус хуульд албан ёсоор хориг тавьсан байна.<sup>6</sup>

Хууль тогтоомжийн тухай хуульд УИХ-аас 2023 оны 5 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан.<sup>7</sup> Эдгээр өөрчлөлтийн тоонд хууль тогтоомжийн төсөлд багадаа 15 хоногийн туршид иргэдийн санал авч байх (38.3 зүйл), хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага нь олон нийтээс санал авах хугацаа дууссанаас хойш хуулийн төсөлд ирүүлсэн бүхий л саналыг хэрхэн тусгасан талаарх мэдээллийг бичгээр гарган, нийтэлж байх үүрэгтэй байх (98.7 зүйл) зэрэг чухал өөрчлөлт тусгагдсан.<sup>8</sup> Эдгээр нь өмнө нь батлагдаж (2021 оны 12 дугаар сар), нэмэлт өөрчлөлт (2022 оны 6 дугаар сар) хийгдсэн Нийтийн сонсголын тухай хуулийн зүйл, заалтуудыг улам сайжруулж өгчээ.<sup>9</sup> Нэмэлт өөрчлөлтүүд нь нийтийн сонсголын товыг тодорхой хугацааны өмнө зарлаж байх (21 дүгээр зүйл), нийтийн сонсголд оролцогчдод хангалттай, үнэн зөв мэдээлэл өгч байх (15 дугаар зүйл), сонсгол дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгох (19 дүгээр зүйл) зэрэг үүргийг зохион байгуулагчдад оногдуулжээ.<sup>10</sup> Бодит хэрэг дээр эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь мэдээлэл ил тод болгох тогтолцооны бат бэх эрх зүйн үндсийг тавьсан ч иргэний нийгмийн төлөөллийн зүгээс Засгийн газар өөрийн санаачилгаар мэдээлэл ил тод болгон түгээхгүй буйг цохон тэмдэглэсэн.<sup>11</sup>

Энэхүү үүрэг амлалт дээр мөн төрийн мэдээлэл түгээх чиглэлээр олон нийтийн оролцооны боломжуудыг үүсгэхэд тодорхой ахиц дэвшил гаргасан байна. КОВИД-19 цар тахлын үеийн нөхцөл байдалд ч Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хэвлэлийн эрх чөлөө, ёс зүйн асуудлаар хэлэлцсэн олон нийтийн арга хэмжээг зохион байгуулж иржээ. Засгийн газар, иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийн талууд нь нийтийн мэдээллийг ил тод болгох арга хандлагын хувьд санал зөрөлдөөнтэй байдаг тул тус зөвлөлийн зүгээс хямралын үед түгээж буй мэдээллийг хэрхэн ашиглах талаар иргэдийн сургах хөтөлбөрийг туршин хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийг Онцгой байдлын ерөнхий газарт хэвшүүлэн институцчилах төлөвлөгөөг боловсруулан гаргасан ч хэрэгжилтийн хугацааны төгсгөлд харахан бодитоор биеллээ олоогүй байна.<sup>12</sup>

Зорилгод хамаарах бусад үйл ажиллагаа нь төлөвлөсөн хэмжээнд бүрэн хэрэгжээгүй байна. Авлигатай тэмцэх газрын зүгээс 2023 оны 6 дугаар сард УИХ-аас эцэслэн баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Олон нийтийн зөвлөлөөр дамжуулан иргэний оролцоог дэмжих, авлигыг хянах үйл явцыг дэмжин ажиллахаар төлөвлөсөн ч хэрэгжилтийн хугацаанд энэхүү зөвлөл байгуулагдаагүй байна.<sup>13</sup> Үндэсний хөтөлбөрийн эцэслэн батлах үйл явц хэрэгжилтийн хугацааны төгсгөл үед хийгдсэн тул төлөвлөсөн мэдээлэл сурталчилгааны ажлууд хийгдээгүй.

Нийтэд нь авч үзвэл энэхүү үүрэг амлалт дээр төрийн мэдээллийн хүртээмжийг сайжруулахад ахиц гаргасан ч тодорхой хязгаарлалтууд байсаар байна. Үүрэг амлалтад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь төрийн зүгээс олон нийтэд нээлттэй болгох мэдээллийн ангиллыг өргөтгөж өгсөн ч Төрийн болон албаны нууцын тухай хуульд хуульд заасан үл хамаарах мэдээллийн ангиллыг тусгаагүй. 2023 онд Фрийдом Хаус байгууллагын гаргасан тайланд энэхүү үүрэг амлалтын хэрэгжилт нь хангалтгүй хэмээн дүгнэсэн.<sup>14</sup> Глоб интернейшнл төвийн хийсэн судалгаагаар Монгол улсад сэтгүүлчдэд тулгарч буй нийтлэг асуудлын нэг нь төрийн зүгээс мэдээлэл гарган өгөхөөс татгалзах явдал буйг тогтоосон.<sup>15</sup> Түүнчлэн онлайн хэлбэрээр түгээж буй төрийн хэд хэдэн мэдээлэл ил тод байдлын хувьд сайжирсан хэмээн ХЗДХЯ-ын зүгээс мэдэгдэж буй ч эдгээр нь энэ үүрэг амлалттай шууд холбоогүй байна.<sup>16</sup>

### **Цаашдын үйл ажиллагаа**

Мэдээллийн ил тод байдлын чиглэлээрх Монгол улсын эрх зүйн орчныг сайжруулахын тулд олон талт хандлага шаардлагатай ба иж бүрэн шинэчлэл хийхийн тулд хэд хэдэн тооны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгож байна. Иргэд цахим өргөдөл гаргах замаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төлөвлөгөөний талаар нийтийн сонсгол зохион байгуулахыг шаардаж, хэрэгжүүлж буй амжилттай жишээн суурилан цаашид явагдах үйл ажиллагаа нь энэхүү үйл явцын илүү өргөжүүлэх, улмаар зөвхөн ИНБ-уудын төлөөллөөр хязгаарлагдахгүйгээр иргэдийн зүгээс өгсөн саналуудыг өргөн хүрээнд тусган, ашиглаж байхыг баталгаажуулахад төвлөрөх шаардлагатай.

Түүнчлэн “төрийн нууц” гэдэгт хамаарах тодорхой, зөв зохистой параметр үзүүлэлт байхгүй нь мэдээллийн ил тод байдлын тухай эрх зүйн орчин дахь томоохон цоорхой болж байна. Цаашид Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, төрийн зүгээс тодорхой мэдээллийг нууцлах, хаалттай байлгах шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах, эсэргүүцэх боломжийг нь нээсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай. Жишээ нь Индонези улсад гэхэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь төрийн байгууллагууд заавал нийтийн мэдээлэл хариуцсан ажилтантай байх, нийтэд нээлттэй мэдээллийн жагсаалтыг олон нийтэд гарган өгч байх, нээлттэй буй бүхий л мэдээллийн тоймыг гаргаж байх зэргийг үүрэг болгосон байдаг.<sup>17</sup>

### **Үүрэг амлалт 3: Төрийн худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх** **Хэрэгжүүлэгч байгууллага:** Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар

#### **Нөхцөл байдалд, зорилтууд**

Энэхүү үүрэг амлалт нь төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг цахимжуулах, авлигын эрсдэл өндөртэй компаниудыг ханган нийлүүлэгчээр сонгон шалгаруулах тохиолдолд мэдээлэх “Улаан дарцаг” үзүүлэлтүүдийг нэвтрүүлэхэд зорьсон. Түүнчлэн амлалтын хүрээнд худалдан авах ажиллагааны онлайн системийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагаанд тавих олон нийтийн хяналтад үүнийг ашиглаж буй байдалд үнэлгээ хийхээр төлөвлөсөн. Эдгээр хүчин чармайлт нь Монгол улс дахь төрийн худалдан авах ажиллагаанд нүүрлээд буй авлигын өндөр эрсдэлийг шийдэх зорилготой.<sup>18</sup> Энэ үүрэг амлалт нь худалдан авах ажиллагааны онлайн өгөгдлийн хүртээмжийг хангах хүчин чармайлтад ахиц гаргасан өмнөх Үйл ажиллагааны төлөвлөгөөнд суурилсан. Төрийн худалдан авах ажиллагааны газрын

манлайлан ажиллах энэхүү үүрэг амлалт нь төрийн байгууллагын зүгээс Үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал болгон оруулсан цорын ганц амлалт юм.

### Урьдчилсан үр дүн: Өндөр

Төрийн худалдан авах ажиллагааг нээлттэй болгох чиглэлээр энэхүү үүрэг амлалт нь тэмдэглүүштэй өндөр үр дүнг гаргажээ. Нийт хийгдэх ажлын хагас нь бүрэн хийгдэж, үлдэх хагас дээр нь томоохон ахиц гараад байна. Энэ ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны өгөгдөл мэдээлэл системтэйгээр нийтлэгдэх байдлыг илүү сайжруулж, тендерийн явцад гарч буй зөрчилд хяналт тавихад ашиглагдаж байна. Мөн тендерийн баримтын цахимаар ирүүлэх, хамаарах өгөгдлийг [tender.gov.mn](http://tender.gov.mn) вэбсайт дээр каталогжуулахад хийх шилжилтэд ахиц гаргаснаар худалдан авах ажиллагааны мэдээллийн хүртээмжийг сайжруулсан. Ардчиллын боловсролын төвийн зүгээс Төрийн худалдан авах ажиллагааны газар нь өгөгдлийн онлайн хэлбэрээр ил тод болгох чиглэлээр тэргүүлэх үүргийг гүйцэтгэж буйг онцлон тэмдэглэсэн ч үйл ажиллагааны төлөвлөгөөний нийтлэг хэрэгжилтэд асуудлууд тулгарч буйг мөн онцолсон.<sup>19</sup>

Төрийн худалдан авах ажиллагааг цахимжуулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Сангийн яамны зүгээс хүчин төгөлдөр буй журмуудыг судлан үзэх Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан Ажлын хэсгийг байгуулсан. Тус Ажлын хэсэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн<sup>20</sup> нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, үүнийг УИХ 2023 оны 6 дугаар сард баталсан.<sup>21</sup> Энэхүү нэмэлт өөрчлөлт нь тендер оролцогчдын цахим мэдээллийн сан үүсгэх, тендер шалгаруулах үйл явцад ил тод байдлыг хангах арга хэмжээ авах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, төрийн байгууллагуудын зарлаж буй тендерийн үнэлгээ хийх ажлыг хэсгийг байгуулах зэрэг үүргийн оногдуулах замаар худалдан авах ажиллагаа дахь хүнээс хамааралтай алдааг бууруулах чиглэлд хандсан.<sup>22</sup>

[tender.gov.mn](http://tender.gov.mn) портал дээр худалдан авах ажиллагааны өгөгдөл мэдээлэл олон нийтэд зориулан тавигдаж, үүнд тендерийн урилга, оролцогчдын нэрсийн жагсаалт (хар жагсаалтад орсон оролцогчид мөн), ялагчид болон гэрээг байнга нийтэлж байна. Өмнө нь тендерийн болон оролцогчдын мэдээллийг тусдаа системүүд дээр байршуулж байв.<sup>23</sup> Ийнхүү нэгтгэснээр баталгаажсан тендер оролцогчид өөрийн тендер саналыг тус порталаар дамжуулан ирүүлэх боломжтой болсон. 2018 оноос эхлэх худалдан авах ажиллагааны цахин каталог хөгжүүлсэн ч төлөвлөгөөний хэрэгжилтийн төгсгөл үед энэхүү каталогийг олон нийтэд хараахан нээгээгүй байна.<sup>24</sup>

Хараат бус тайлагналын механизмын зүгээс гаргасан зөвлөмжийн дагуу порталын хэрэглэгчийн харилцах интерфэйсийн дизайнд томоохон өөрчлөлт хийсэн. Жишээ нь тендер оролцох урилгыг харахад порталын хэрэглэгчид нь огноо, тендерийн нэр, төсвийн багц захирагч болон ажил үйлчилгээний төрөл зэргээр нь нэмэлт өөрчлөлт хийгдсэн хуулийн дагуу хайх боломжтой болжээ.<sup>25</sup> Нээлттэй нийгэм форумын зүгээс тус портал нь Нээлттэй гэрээний өгөгдлийн стандартын (OCDS) дагуу холбоос үүсгэн худалдан авах ажиллагааны өгөгдөлтэй холбогдсон ч эдгээр холбоос дээр дарахад алдаа заасан мессеж ихээр ирж буйг гарган ирсэн. Портал дээрх мэдээлэл нь хэрэгжилтийн хугацаанд төгсгөл гэхэд ихээхэн нэмэгджээ. 2023 оны 6 дугаар сарын байдлаар нэгдсэн системд 17,000 гаруй тендерийн урилга нийтлэгдсэн буй нь хэрэгжилтийн нийт хугацаанд явагдсан төрийн худалдан авах ажиллагааны нийт тендерийг багтаажээ. 286,000 тендерийн лавлагааг татан авсан буй нь хэрэглэгчдийн оролцоо, ашиглалт өндөр буйг харуулж байна.<sup>26</sup>

Энэхүү үүрэг амлалт дээр мөн төрийн эгэх хариуцлагын механизмын чиглэлд ахиц дэвшил гаргаад байна. Хэрэгжилтийн хугацааны төгсгөл үе гэхэд төлөвлөж буй Улаан дарцаг (Red Flag) системийн хөгжүүлэлт хийгдэж байна. Энэхүү хөгжүүлэлтийн үйл явцад шаардлагатай мэдээллийг ханган өгөхийн тулд Төрийн худалдан авах ажиллагааны газар нь тендер зарын болон саналын системүүдийг нэгтгэхдээ шаардлагатай өгөгдөл мэдээллийг цуглуулж, тендер оролцогчид болон иргэдээс саналыг авсан байна.<sup>27</sup> Тус агентлагийн зүгээс мөн [opendata.tender.gov.mn](http://opendata.tender.gov.mn) порталыг нээн ажиллуулж, иргэдэд [tender.gov.mn](http://tender.gov.mn) порталын програмчлалын аппликейшны интерфэйст (API) нэвтрэх боломж олгосноор тендерийн мэдээллийг олон нийтийн хяналт, мониторингийн зориулалтаар ашиглах боломжтой болжээ.<sup>28</sup> Засгийн газрын хяналт, шалгалтын албыг 2023 оны эхэнд олон нийтээс ирүүлсэн гомдлын дагуу хяналт шалгалт хийх, улсын төсвийн зарцуулалт, төрийн үйлчилгээ, гэрээ хэлцэл зэрэгт хараат бус хяналт шалгалт хийх чиг үүрэгтэйгээр байгуулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний төгсгөл үеийн байдлаар энэхүү шинээр үүссэн байгууллага нь шинээр хяналт-шинжилгээ, үнэлгээний бодлого, журмыг боловсруулах ажлыг хийх шатанд байна.<sup>29</sup>

Сангийн яамны үзэж буйгаар энэхүү үүрэг амлалт, хэрэгжилт нь авлигын эрсдэлийг бууруулахад дэмжлэг болжээ. Худалдан авах ажиллагааг цахимжуулснаар хамаарах талууд нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, шүүхийн шийдвэр, тендер оролцогчдын баталгаа, тоног төхөөрөмж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга хэмжээ, өмнөх тендерүүд зэрэг олон мэдээллийг шалгах, баталгаажуулах боломжтой болжээ.<sup>30</sup> Тендер ялагч талын ирүүлсэн материалыг олон нийт шалгаж байх явц мөн эхлэн явагдаж байна. 2023 оны 7 дугаар сарын байдлаар тендер ялалт байгуулсан 1,891 оролцогчдын ирүүлсэн 34,443 баримт бичгийн 1,921-ийг олон нийтийн хяналт хийгээд байна.<sup>31</sup> Түүнчлэн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдсан талууд нь байнгын утасны шугам ашиглан олон нийттэй зөвлөлдөж, саналыг нь авсан нь нийт 25,000 минутын ярианы бичлэг, 3,800 цахим шуудан хэлбэрээр хадгалагдаж буй нь энэхүү арга ажиллагааг институцчилах үйл явц тогтвортой явагдаж буйг харуулж байна.<sup>32</sup> Энэхүү арга ажиллагаа нь тендер ялагчтай хийх гэрээ нь хамаарах журмын дагуу хийгдсэн болохыг шалган баталгаажуулахад иргэд шууд тодорхой үүрэг роль гүйцэтгэх боломжийг хангаж байна. Тендерийн үйл ажиллагаанд буй ямар нэгэн зөрчлийг олж тогтоосноор төрийн худалдан авах ажиллагаанд буй буруутай үйлдэл, хүний хүчин зүйлээс хамаарсан алдаа зэргийг олж илрүүлэхэд ашиглаж болно. Үүнтэй зэрэгцэн сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагууд ч худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг авлигатай тэмцэхэд ашиглах боломжтой болжээ. Жишээ нь Монголын дата клуб нь ханган нийлүүлэгчид болон 533 төрийн албан хаагч, улс төрчид хоорондын хамаарлыг энэхүү мэдээллийг ашиглан илрүүлжээ.<sup>33</sup>

### Цаашдын үйл ажиллагаа

Төрийн худалдан авах ажиллагаа нь авлигын эрсдэл өндөртэй үйл явц ба ялангуяа тендер ялах, гэрээ байгуулахад авлига, хээл хахуулийн асуудал байнга дагалдаж байдаг.<sup>34</sup> Төрийн худалдан авах ажиллагааг цахимжуулахын зэрэгцээ нээлттэй өгөгдлийн стандартыг нэвтрүүлэх нь эрсдэлийг бууруулахад түлхэц болохын зэрэгцээ энэ чиглэлийн хүчин чармайлтуудыг төрийн бүхий л үл ажиллагаанд уялдуулан төлөвшүүлэх шаардлагатай. Жишээ нь Засгийн газар нь гэрээний гүйцэтгэл, төлбөр, гүйцэтгэсэн ажлын үнэлгээ зэрэг тендерийн дараах шатны үйл явцын ил тод байдал, олон нийтийн оролцоог ханган өргөтгөх илүү өндөр хэмжээний зорилт бүхий шинэчлэлд зорин ажиллаж болно.

2023 оны 6 дугаар сард<sup>35</sup> Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан гаргасан нь энэхүү зорилтыг хангах илүү их боломжуудыг нээж, авлигын, тэр дундаа худалдан авах ажиллагаанд буй авлигын эсрэг үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэхэд түлхэц болжээ.<sup>36</sup> Монгол улс дахь төрийн худалдан авах үйл ажиллагаанд хийсэн үнэлгээндээ Азийн хөгжлийн банк нь тендерийн баримт бичигтэй холбоотой журмуудыг шинэчлэх, төв болон орон нутгийн түвшинд хийгдэж буй худалдан авах ажиллагааг зөв зохицуулах, хяналт тавьж байх хэрэгцээ өндөр буйг дурджээ.<sup>37</sup>

## **Үүрэг амлалт 9: Төрийн үйлчилгээг цахимжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх**

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Цахим хөгжил, харилцаа холбооны яам

### **Нөхцөл байдал, зорилтууд**

Энэхүү үүрэг амлалт нь [e-mongolia.mn](http://e-mongolia.mn) платформ дээр үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах замаар цахим орон зай дахь үйлчилгээг үзүүлэх, мөн хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Тус платформ нь өдөр тутмын үйлчилгээг (жишээ нь иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлт, хууль сахиулах чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлэх гэх мэт) иргэд, мөн бизнес эрхлэгчдэд (хуулийн этгээдийн бүртгэл, татвар болон үл хөдлөх хөрөнгө) ойртуулан, үзүүлдэг.

Үүрэг амлалтын хэрэгжилтээс өмнө ч E-Mongolia порталыг иргэд өргөн хүрээнд ашиглаж байжээ. 2021 оны 12 дугаар сарыг 9-ны байдлаар буюу Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө хүчин төгөлдөр болохоос хэдэн долоо хоногийн өмнө тус портал нь 1,934,723 идэвхтэй хэрэглэгчтэй, төрийн 500 үйлчилгээг онлайн хэлбэрээр үзүүлдэг байв.<sup>38</sup> Энэ үзүүлэлт нь тухайн портал нь хэрэгжилтээс өмнө 6,145,809 хэрэглэгчид хэдийн үйлчилгээ үзүүлсэн байсныг харуулж байна.<sup>39</sup> Энэхүү үүрэг амлалтын хүрээнд Засгийн газар нь илүү олон тооны үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар (нэг цэгийн үйлчилгээний портал үүсгэх) үйлчилгээ үзүүлэх, мөн үйлчилгээ нэг бүрийн хэрэглээг нэмэгдүүлэхээр зорин ажилласан.

### **Эрт үеийн үр дүн: Дунд зэрэг**

Засгийн газрын зүгээс E-Mongolia платформыг шинэчлэн, үүрэг амлалтын хүрээнд тусгагдсан бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулжээ. Гэвч төрийн үйлчилгээг үр ашигтай хүртээмжтэй болгох нь нээлттэй засгийн үнэт зүйлстэй шууд холбоогүй юм. Нээлттэй засгийн чиглэлийн үр дүнгийн хувьд платформын дагалдах бүтээгдэхүүн нь төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжийг хангах чиглэлээр дунд хэмжээнд үр дүнг үзүүлжээ.

Хэрэгжилтийн хугацаанд Google Play Store болон Apple App Store дээр байршуулсан үнэгүй аппликейшн болон вебд суурилсан порталыг сайжруулснаар платформд нэвтрэн ашиглагчдын тоо, үйлчилгээний хүртээмж нэмэгджээ. Түүнчлэн 2023 оны 4 дүгээр сард тусдаа E-Business платформыг Ерөнхий сайд албан ёсоор нээсэн ба энэ нь бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдэд зориулсан төрийн үйлчилгээг нэгтгэсэн платформ юм.<sup>40</sup>

E-Mongolia платформ нь өмнө нь төвлөрсөн байдлаар нэгтгэгдээгүй байсан олон тооны төрийн үйлчилгээг (2021 оны 12 дугаар сард 500 үйлчилгээ байсан бол 2023 оны 8 дугаар сарын байдлаар 1,448 үйлчилгээ орсон) авах боломжийг нээн өгчээ.<sup>41</sup> Бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд зориулсан тусдаа портал нээгдсэн тул 2021 оны 12 дугаар сард 1,934,723

байсан идэвхтэй хэрэглэгчдийн тоо 2023 оны 8 дугаар сарын байдлаар 1,603,678 болж буурсан. Гэвч энэхүү буурсан тоо ч Монгол улсын нийт хүн амын (2022 оны байдлаар 3,398,366)<sup>42</sup> хагастай тэнцэж буй нь иргэд өндөр хэмжээнд порталыг ашиглаж буйг харуулж байна.

Төрийн зүгээс иргэдэд үзүүлж буй төрөл бүрийн үйлчилгээг үнэлэхийн зэрэгцээ хэрэглэгчид нь тухайн мэдээллийг ашиглан портал дээр буй үйлчилгээг шууд авах боломжтой буйг Ардчиллын боловсрол төвийн зүгээс тэмдэглүүштэй хэмжээнд ахиц гарсан хэрэг үзэж байна.<sup>43</sup> Жишээ нь иргэд иргэний үнэмлэх эсвэл гадаад паспорт авах зэрэг үйлчилгээг авахад шаардлагатай бүхий л шатаар дамжин иргэд бүхэлдээ онлайн порталаар дамжуулан энэхүү үйлчилгээг авах боломжтой байна.<sup>44</sup> Үүний нэгэн адил E-Business платформ нь шинээр бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл авах бол хоёр өдрийн дотор үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн. Үндсэнд нь аваад үзвэл тухайн платформууд нь онлайнгаар үнэлгээ өгөх болон авах боломжтой цахим үйлчилгээний төрөл, тоог, ашиглалтыг ихээхэн нэмэгдүүлжээ (2021 оны 12 дугаар сард 6,145,809 байсан бол 2023 оны 8 дугаар сард 29,052,441 болж нэмэгдсэн).<sup>45</sup> Үр ашиг муутай, цаг их авдаг хүнд сурталт журмуудыг багасгаснаар Засгийн газар нь энэхүү платформыг авлигатай тэмцэхэд дэмжлэг болж буй хэмээн үзэж, “Монгол улсыг бизнест ээлтэй болгож, шаардлагатай гадаадын хөрөнгө оруулалт татахад чухал үүрэг гүйцэтгэж байна” хэмээн үзэж байна.<sup>46</sup>

2020 онд 66% байсан интернэтийн нэвтрэлтийн хувь хэмжээ 2021 онд 84%<sup>47</sup> болж томоохон өсөлт гаргахын зэрэгцээ энэхүү үүрэг амлалт нь дэд бүтэц эсвэл чадавхын асуудлаас үүдэн интернэтийн хүртээмж хязгаар буй иргэдэд, тэр дундаа өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, алслагдсан хөдөө орон нутгийн иргэдэд зориулан хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай буйг дурдсан ХБТМ-ын өмнөх тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлжээ. E-Mongolia төвийн ажилтнууд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 395 төрийн үйлчилгээний төвүүд, мөн 3 дүүрэг, 13 аймгийн төв, орон нутгийн 8 цагт байршин ажиллаж буй “Хурдан” төвүүдэд суурин ажиллаж байна.<sup>48</sup>

Үйл ажиллагааны хэрэгжилтийн хугацаанд E-Mongolia платформд хийгдсэн шинэчлэл нь мөн хүртээмж илүү сайн хангах функцуудыг Веб контентын хүртээмжийн зааварчилгаанд (WCAG)<sup>49</sup> тусгагдсан, хэрэглэгчдийн зүгээс дэлгэцийн нягтаршил, үсгийн хэмжээ, текст хоорондын зай, шөнийн горим ашиглах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тусгай ID ашиглах боломжийг хангасан стандартад нийцүүлэхэд түлхэц болжээ. Эдгээр нэмэлт функцүүд нь тусгайлан харааны, сонсголын бэрхшээлтэй болон хэт мэдрэгшил бүхий хүмүүст дэмжлэг болох зорилгоор төлөвлөгджээ.<sup>50</sup> Түүнчлэн лайв чат функцийг нэмэлтээр оруулсан нь ашиглах, хариу авахад хүндрэлтэй тулгарч буй хүмүүст шууд дэмжлэг үзүүлэх боломжийг нээжээ.<sup>51</sup> Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зүгээс алсдагдсан газрууд дахь дэд бүтцийн хомсдол, технологийн мэдлэг тааруу буй байдал, шуудангийн хаягжилтын тогтолцоо бүрэн бүрдээгүй зэрэг асуудлуудыг хэрэгжилтэд тулгарч буй асуудлууд хэмээн тодорхойлон гаргасан.<sup>52</sup> Үйл ажиллагааг хэвийн хэмжээнд үр ашигтай хадгалан үргэлжлүүлэх зорилгоор энэхүү платформыг хиймэл оюуны функцүүдтэй холбож, хэрэглэгчийн нэвтрэлт, сүлжээний урсгал, ачааллын түвшин зэрэгт үндэслэн боловсруулалт хийж чадавхыг тохируулах болжээ.<sup>53</sup>

Үндсэндээ Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зүгээс хэрэгжүүлэгч агентлагийн хувьд E-Mongolia платформыг сайжруулах, E-Business платформыг шинээр хөгжүүлэхэд

хүртээмжтэй дизайныг баримтлах замаар институцын дэмжлэг техникийн, чадавхыг болон санхүүгийн хэлбэрээр үзүүлсэн нь энэхүү үүрэг амлалтад чухал түлхэц болжээ. Улмаар Стандарт, хэмжил зүйн үндэсний төвийн зүгээс Төрийн үйлчилгээг операторын горимоор гүйцэтгэхэд тавих ерөнхий шаардлагыг (MNS 6984:2022) эцэслэн баталж, үйл ажиллагаанд хэвшүүлсэн байна.<sup>54</sup>

### Цаашдын үйл ажиллагаа

Энэхүү үүрэг амлалтын хүрээнд гараад буй дунд хэмжээний эрт үеийн үр дүн нь 2025 он гэхэд цахим үндэстэн болсон байх Монгол улсын 5 жилийн төлөвлөгөөний чухал нэгэн үзүүлэлт болно.<sup>55</sup> Цаашид Засгийн газар нь иргэдийн хувийн мэдээлэлд боловсруулалт хийхэд нууцлалыг хадгалах, иргэдийг хамгаалахын тулд өгөгдлийн менежментийн стандартыг хамтран бүрдүүлэхэд НЗТ-ийн платформыг ашиглаж болно. Ингэснээр иргэдийн зүгээс төрийн үйлчилгээний чанарын талаар өөрийн санал бодлыг илэрхийлэх, үүнд хариу арга хэмжээ авах төрийн эгэх хариуцлагыг бүрдүүлэх илүү хүчирхэг механизмыг нэвтрүүлэх боломжтой.

<sup>1</sup> “Freedom in the World 2020, Mongolia,” Freedom House, <https://freedomhouse.org/country/mongolia/freedom-world/2020> (accessed 2 November 2023); “Media Freedom Report 2020,” Globe International Center, 10 August 2021, <https://www.gic.mn/en/post/r/1423>. (Дэлхийн эрх чөлөө 2020, Монгол улс) 2023 оны 11 дүгээр сарын 2-ны байдлаар.

<sup>2</sup> “Нийтийн сонсголын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт,” Монгол улсын Засгийн газар, 2021 оны 12 дугаар сарын 24, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11225&type=2>

<sup>3</sup> Б.Болорсайхан, Д.Номинчимэг (Хүний эрхийн үндэсний комисс), ХБТМ-ын асуумж, 2023 оны 7 дугаар сарын 19.

<sup>4</sup> “Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийг “Цахим орчинд хяналт тавих хууль”-д ХОРИГ тавихыг хүссэн өргөдөл,” [Petition demanding President U. Khurelsukh to veto the Social Network Control Law], United Info Hub, accessed 3 August 2023, <https://www.uih.mn/petition/view/17>.

<sup>5</sup> Cédric Alviani, “Mongolia: RSF commends presidential veto of a dangerous social media bill, Reporters Without Borders,” 27 January 2023, <https://rsf.org/en/mongolia-rsf-commends-presidential-veto-dangerous-social-media-bill>. (Монгол улс: Хил хязгааргүй сурвалжлагчид байгууллагын зүгээс нийгмийн сүлжээнд хяналт тавих хуульд Ерөнхийлөгч хориг тавьсныг сайшаав)в

<sup>6</sup> Gemma B. Mendoza, Mongolian president vetoes controversial social media law, Rappler, 30 January 2023, <https://www.rappler.com/technology/social-media/mongolian-president-vetoes-controversial-social-media-law>. (Монгол улсын Ерөнхийлөгч нийгмийн сүлжээний тухай хуульд хориг тавилаа, 2023 оны 1 дүгээр сарын 30)

<sup>7</sup> “Хууль тогтоомжийн тухай хууль,” Монгол улсын Засгийн газар, 2023 оны 5 дугаар сарын 4-ны өдөр нэмэлт өөрчлөлт хийгдсэн, <https://legalinfo.mn/en/edtl/16759676308921>.

<sup>8</sup> “Хууль тогтоомжийн тухай хууль,” Монгол улсын Засгийн газар.

<sup>9</sup> “Нийтийн сонсголын тухай хууль,” Монгол улсын Засгийн газар, 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдөр нэмэлт өөрчлөлт хийгдсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11225>.

<sup>10</sup> “Нийтийн сонсголын тухай хууль,” Монгол улсын Засгийн газар.

<sup>11</sup> Г.Ундрал (Ардчиллын боловсрол төв), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2023 оны 10 дугаар сарын 9.

<sup>12</sup> “НЗТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023,” Монгол улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 2023 оны 8 дугаар сарын 31, <https://irgen-tur.mn/file/download/37>, 10–11.

<sup>13</sup> П.Батзаяа, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдлаа,” 2023 оны 6 дугаар сарын 30, <https://news.mn/r/2658523>.

<sup>14</sup> Freedom in the World 2023, Mongolia,” Freedom House, <https://freedomhouse.org/country/mongolia/freedom-world/2023> (Дэлхийн эрх чөлөө 2020, Монгол улс) 2023 оны 11 дүгээр сарын 2-ны байдлаар..

<sup>15</sup> “Улс төрийн үйл явц дахь үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, мэдээлэлтэйгээр оролцох эрх” Глоб Интернейшнл төв, 2023 оны 5 дугаар сарын 10, <https://www.gic.mn/en/post/r/1729/>.

<sup>16</sup> “Албан тоот No. ХЭГ/721,” Хууль зүй, дотоод хэргийн яам, 2023 оны 3 дугаар сарын 30

<sup>17</sup> Дараахыг үзнэ үү: “Law of Indonesia on Public Information Transparency,” Government of Indonesia, 30 April 2008, [https://www.peraturan.go.id/files2/uu-no-14-tahun-2008\\_terjemah.pdf](https://www.peraturan.go.id/files2/uu-no-14-tahun-2008_terjemah.pdf). (Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Индонези улсын Засгийн газар)

<sup>18</sup> Risk & Compliance Portal, “Mongolia Corruption Report,” *GAN Integrity* (May 2020), (Эрсдэл, комплаянсын портал, Монгол улсын авлигын тайлан) <https://www.ganintegrity.com/portal/country-profiles/mongolia/>.

- <sup>19</sup> Г.Ундралтай хийсэн ярилцлага.
- <sup>20</sup> Б.Болорсайхан, Д.Номинчимэг, ХБТМ-ын асуумж.
- <sup>21</sup> “НЗТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023,” Монгол улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 12.
- <sup>22</sup> “НЗТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023,” Монгол улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 12–13.
- <sup>23</sup> “Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө 2021–2023,” НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 2021 оны 12 дугаар сарын 31, [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/01/Mongolia\\_Action-Plan\\_2021-2023\\_EN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/01/Mongolia_Action-Plan_2021-2023_EN.pdf), 21.
- <sup>24</sup> “НЗТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023,” Монгол улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 13.
- <sup>25</sup> “Тендерийн урилга хайх,” [Invitation to tender], Төрийн худалдан авах ажиллагааны газар, 2023 оны 8 дугаар сарын 19-ны байдлаар, <https://www.tender.gov.mn/mn/index>.
- <sup>26</sup> “НЗТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023,” Монгол улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 13.
- <sup>27</sup> Б.Болорсайхан, Д.Номинчимэг, ХБТМ-ын асуумж.
- <sup>28</sup> Дараахыг үзнэ үү: “Using data from procurement systems for infrastructure monitoring,” Open Contracting Partnership, accessed 16 October 2023, <https://standard.open-contracting.org/infrastructure/latest/en/guidance/using>. (Дэд бүтцийн мониторингийн зорилгоор худалдан авах ажиллагааны өгөгдлийг ашиглах нь), Нээлтэй гэрээний түншлэл.
- <sup>29</sup> “Төрийн бодлогод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж шинэчлэн боловсруулах баримт бичиг,” Монголын үнэлгээний холбоо, 2023 оны 6 дугаар сар, <https://www.mongolianevaluation.mn/31/nitem>. ( )
- <sup>30</sup> Б.Болорсайхан, Д.Номинчимэг, ХБТМ-ын асуумж.
- <sup>31</sup> Б.Болорсайхан, Д.Номинчимэг, ХБТМ-ын асуумж.
- <sup>32</sup> “НЗТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023,” Монгол улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 14.
- <sup>33</sup> Б.Дэлгэрмаа, П.Эрдэнэчимэг, “Digging out data to shine a light on public buying in Mongolia,” Open Contracting Partnership, 2023 оны 10 дугаар сарын 11, <https://www.open-contracting.org/2023/10/11/digging-out-data-to-shine-a-light-on-public-buying-in-mongolia>. (“Монгол улс дахь төрийн худалдан авалтад гэрэл тусгах өгөгдлийг шинжлэх нь)
- <sup>34</sup> “Mongolia risk report,” GAN Integrity, 2020 оны 11 дүгээр сарын 5-нд шинэчилсэн, <https://ganintegrity.com/country-profiles/mongolia/#public-procurement>. (Монгол улсын эрсдэлийн тайлан, GAN Integrity)
- <sup>35</sup> П.Батзаяа, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдлаа,” 2023 оны 6 дугаар сарын 30, <https://news.mn/r/2658523>.
- <sup>36</sup> Д.Болор, “What’s in Mongolia’s new anti-corruption strategy?” The Diplomat, 2023 оны 6 дугаар сарын 8, <https://thediplomat.com/2023/06/whats-in-mongolias-new-anti-corruption-strategy>. (Монгол улсын Авлигатай тэмцэх стратегид шинээр юу тусгагдав?)
- <sup>37</sup> “Mongolia: Strengthening of public procurement for improved project implementation,” Азийн хөгжлийн банк, 2022 оны 4 дүгээр сар, <https://www.adb.org/sites/default/files/project-documents/49193/49193-001-tcr-en.pdf>, 4. (Монгол улс: төслийн хэрэгжилтийг сайжруулахын тулд төрийн худалдан авах ажиллагааг сайжруулах нь)
- <sup>38</sup> “E-Mongolia,” E-Mongolia, 2023 оны 12 дугаар сарын 19-ны байдлаар, <https://web.archive.org/web/20211209040105/https://e-mongolia.mn/home>.
- <sup>39</sup> “E-Mongolia (Wayback Machine 9 December 2021),” E-Mongolia.
- <sup>40</sup> “New Mongolian E-Business platform to make it easier to start and grow a business,” Yahoo! Finance, 2023 оны 4 дүгээр сарын 11, <https://finance.yahoo.com/news/mongolian-e-business-platform-easier-154900214.html>. (Шинэ E-Business платформ нь бизнес эхлэх, өргөтгөхөд хялбар болголоо).
- <sup>41</sup> “E-Mongolia,” E-Mongolia, 2023 оны 8 дугаар сарын 19-ны байдлаар, <https://e-mongolia.mn/home>.
- <sup>42</sup> “Монгол улсын нийт хүн ам,” Дэлхийн банк, 2023 оны 9 дугаар сарын 19-ны байдлаар, <https://data.worldbank.org/indicator/SP.POP.TOTL?locations=MN>.
- <sup>43</sup> Г.Ундрал, 2023 оны 10 дугаар сарын 9.
- <sup>44</sup> Б.Болор-Эрдэнэ, “How to do digital government: Experiences from E-Mongolia,” Urbanet, 8 February 2022, <https://www.urbanet.info/digital-governance-mongolia>. (Цахим засгийг хэрхэн бүрдүүлэх вэ: E-Mongolia хөтөлбөрийн туршлага)
- <sup>45</sup> “E-Mongolia,” E-Mongolia, 2023 оны 8 дугаар сарын 19-ны байдлаар, <https://e-mongolia.mn/home>.
- <sup>46</sup> “New Mongolian E-Business platform to make it easier to start and grow a business,” Yahoo! Finance. (Шинэ E-Business платформ нь бизнес эхлэх, өргөтгөхөд хялбар болголоо)
- <sup>47</sup> “Монгол улсын интернэт хэрэглэгчид (%) – Монгол улс,” Дэлхийн банк, 2023 оны 8 дугаар сарын 19-ны байдлаар, <https://data.worldbank.org/indicator/IT.NET.USER.ZS?locations=MN>.



---

<sup>48</sup> “Албан бичиг No. ХЭГ/721,” Цахим хөгжил, харилцаа холбооны яам, 2023 оны 3 дугаар сарын 30; Б.Болор-Эрдэнэ, “How to do digital government: Experiences from E-Mongolia,” Urbanet. (Цахим засгийг хэрхэн бүрдүүлэх вэ: E-Mongolia хөтөлбөрийн түршлага)

<sup>49</sup> “WCAG 2 overview,” Web Accessibility Initiative, accessed 17 August 2023, <https://www.w3.org/WAI/standards-guidelines/wcag/#:~:text=The%20WCAG%20standards%20have%2012,A%2C%20AA%2C%20and%20AAA>. (Веб контентын хүртээмжийн зааварчилгаа 2 дугаар хяналт, Веб хүртээмжийн санаачилга, 2023 оны 8 дугаар сарын 17)

<sup>50</sup> “Албан бичиг No. ХЭГ/721,” Цахим хөгжил, харилцаа холбооны яам.

<sup>51</sup> “Албан бичиг No. ХЭГ/721,” Цахим хөгжил, харилцаа холбооны яам.

<sup>52</sup> “Албан бичиг No. ХЭГ /721,” Цахим хөгжил, харилцаа холбооны яам.

<sup>53</sup> НЭТ-ийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023,” НЭТ-ийн Үндэсний зөвлөл, 27.

<sup>54</sup> “НЭТ-ийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023,” НЭТ-ийн Үндэсний зөвлөл, 28.

<sup>55</sup> Б.Болор-Эрдэнэ, “How to build a ‘digital nation’: Perspectives from Mongolia,” University of Oxford Blavatnik School of Government, 8 February 2021, <https://www.bsg.ox.ac.uk/blog/how-build-digital-nation-perspectives-mongolia>. (Б.Болор-Эрдэнэ, “Цахим үндэстнийг хэрхэн бий болгох вэ: Монгол улс”, Оксфордын их сургууль, Блатавник Засаглалын сургууль, 2021 оны 2 дугаар сарын 8).

## Бүлэг III. Оролцоо, хамтран боловсруулах үйл явц

***Оролцоог хангах, хамтын оролцоотой боловсруулах чиглэлээр тавигддаг минимум стандартыг Үндэсний үйл ажиллагааны хоёр болон гуравдугаар төлөвлөгөөний мөчлөгт ханган биелүүлээгүй үр дүн гарсны дараа дөрөвдүгээр төлөвлөгөөний хүрээнд Монгол улсад явагдаж буй НЗТ-ийн үйл явц дээр бага зэрэг ахиц гарсан. Гэсэн ч төрийн албан хаагчид ойр ойрхон солигдож буй, төсөв хөрөнгө дутмаг, төрийн голлох байгууллагуудын дунд манлайллын хоосон орон зай үлдсэн зэрэг асуудлуудаас үүдэн үндсэн үйл явц нь нийт хэрэгжилтийн хугацаанд иргэний нийгмийн оролцогч талуудтай холбоо харилцаагүй явагджээ.***

Үндэсний үйл ажиллагааны дөрөвдүгээр төлөвлөгөөний хугацаанд Монгол улс дахь НЗТ-ийн үйл явцын хариуцан зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага хоёр удаа солигдсон. Өмнөх төлөвлөгөөний үед гол хариуцагч, зохицуулагч байгууллага байсан ЗГХЭГ нь энэхүү чиг үүргээ 2022 оны 9 дүгээр сарыг хүртэл гүйцэтгэсэн. Үүний дараа Эдийн засаг, хөгжлийн яам энэхүү чиг үүргийг 2023 оны 3 дугаар сарыг хүртэл гүйцэтгэсэн. 2023 оны 3 дугаар сараас эхлэн ЗГХЭГ-ийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг Хүний эрхийн үндэсний комисс зохицуулагчаар томилогджээ. Засгийн газрын гишүүн сайд нарын түвшинд, ялангуяа Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд зэрэг албан тушаалтнууд шинээр томилогдсон. Энэхүү сэлгээнээс үүдэн шинээр томилогдсон сайд нар НЗТ-ийн үйл явцтай танилцаж, ойлголт авахын тулд тодорхой хугацаа шаардагдсанаас үүдэн түншлэлийн хэрэгжилт суларч ирсэн.

Монгол улс дахь НЗТ-ийн олон талын оролцоот форум болох Үндэсний зөвлөл 2023 оны 7 дугаар сарыг (хэрэгжилтийн хугацаа дуусахаас гурван сарын өмнө) хүртэл хуралдаагүй, үүрэг амлалтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор төр болон иргэний нийгэм хоорондын уулзалт, зөвлөлдөх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.<sup>1</sup> Үүрэг амлалтын хэрэгжилттэй хамаарах зарим үйл ажиллагаанд иргэний нийгмийн зарим байгууллага оролцсон ч тэдний оролцоо нь байнгын, жигд бус, олон талын оролцоот форумын зохицуулалт байхгүй. Дээр дурдсан өөрчлөлтүүд нь 2021 онд хамтран боловсруулах үйл явц будилаантай явагдсаны дараагаар сайжирч эхэлж байсан төр болон иргэний нийгэм хоорондын хамтын ажиллагааны түвшнийг буцаан бууруулсан.<sup>2</sup>

Үүнээс өмнөх хугацаанд төрийн албан хаагчид хурдтай солигдсоноос эхлэн улс төрийн удирдлагын түвшинд гарсан шилжилт зэргээс үүдэн Монгол улс нь үйл ажиллагааны хоёрдугаар төлөвлөгөөний хэрэгжилтийн болон үйл ажиллагааны гуравдугаар төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилтийн хугацаанд НЗТ-ийн үйл явцыг зөрчсөн.<sup>3</sup> Төлөвлөлт, хэрэгжилтийн мөчлөг дамнуулан минимум шаардлагуудыг ханган биелүүлээгүй тул НЗТ-ийн Шалгуур, стандартын дэд хорооны зүгээс процедурын хяналт хийхэд хүрсэн.<sup>4</sup>

Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний хамтран боловсруулах явцад бага зэрэг ахиц гарсан нь НЗТ-ийн оролцоог хангах босго шаардлагыг Монгол улс хангахад түлхэц болжээ.<sup>5</sup> Үүний хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад иргэдийн зүгээс ирүүлсэн саналыг хэрхэн тусгасан, харгалзсан талаар үндэслэл бүхий хариу байсан нь шаардлагыг хангахад хүргэсэн гол үзүүлэлт байсан. Иргэний нийгмийн оролцогч талууд 2021 оны 1 дүгээр сараас эхлэн төлөвлөлтийн бэлтгэл уулзалтуудыг зохион байгуулсан. НЗТ-ийн Ажлын албанаас Хяналтад хамруулах тухай албан бичиг хүлээн авсны дараагаар<sup>6</sup>

Ерөнхий сайдын Засаглалын асуудал хариуцсан зөвлөхийн зүгээс хамтран боловсруулах үйл явцын талаар иргэний нийгмийн байгууллагуудтай харилцан зөвлөлдөж эхэлсэн. Хамтран боловсруулах үйл явц дахь төрийн албан ёсны оролцоо 2021 оны 9 дүгээр сараас эхэлж, Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Засгийн газар, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөллийн оролцоотойгоор байгуулан ажиллуулсан. Энэхүү үйл явцын хүрээнд үүрэг амлалтуудын саналыг авч, улмаар эдгээрийг нарийвчлан 9 үүрэг амлалт болгосон ба эдгээрээс зөвхөн нэгийг нь (Үүрэг амлалт 3) төрийн байгууллагын зүгээс санал болгон оруулсан. 2021 оны 12 дугаар сард төлөвлөгөөг эцэслэн батлах үеэр Засгийн газар нь иргэний нийгэмтэй зөвлөлдөжгүйгээр санал болгосон зарим үүрэг амлалтын хамрах хүрээнд өөрчлөлт оруулсан.<sup>7</sup> Өмнөх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулбал энэхүү үйл явц нь иргэний нийгмийн оролцогч талуудыг түлхүү төлөөлсөн олон талт бүлгийг (жишээ нь хэвлэлийн эрх чөлөөний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг шинэ ИНБ-уудыг оролцуулах гэх мэт) хамруулсан.<sup>8</sup>

Энэ нь тодорхой хэмжээнд эерэг дохио өгсөн ч Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа зогсонги байснаас үүдсэн удирдлага манлайллын хоосон орон зай, төрийн албан хаагчдын халаа сэлгээ зэрэг нь хэрэгжилтийн хугацаанд төр болон иргэний нийгмийн хамтын ажиллагааг бүрэн хэмжээнд зогсоосон. Үүн дээр нэмээд НЗТ-д зориулсан төсвийн хомсдол, мөн ХЭҮК-ын зүгээс тайлбарласнаар КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нөлөөлөл мөн нэрмээс болжээ.<sup>9</sup> Тиймээс хэрэгжүүлэгч байгууллагууд нь үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг өөрийн хязгаарлагдмал төсвөөс зарцуулж, боломжит өндөр үр дүнг хангах боломж хязгаарлагдаж иржээ.

2023 оны 3 дугаар сард Засгийн газар тогтоол гаргаж Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөн төрийн 15 өндөр албан тушаалтан (үүнд ЗГХЭГ-ын даргыг Үндэсний зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэх), иргэний нийгмийн 5 төлөөлөлтэй байхаар өөрчилсөн.<sup>10</sup> Шинэчлэгдсэн энэхүү форум нь 2023 оны 7 дугаар сарын 4 болон 29-ны өдрүүдэд хоёр удаа хуралдсан. Эдгээр хурлуудаар Засгийн газар болон иргэний нийгмийн оролцогчид үйл ажиллагааны дөрөвдүгээр төлөвлөгөөний хэрэгжилт, дараагийн төлөвлөгөөг хамтран боловсруулах бэлтгэл ажлын талаар хэлэлцсэн.<sup>11</sup>

Энэхүү үүсэн бий болсон таатай нөхцөлийг зөвхөн хамтран боловсруулах шат ч бус мөн дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн шатанд ч тогтвортой хадгалах нь чухал юм. Үүний тулд ХЭҮК болон НЗТ-ийн Үндэсний зөвлөлд олгох төсвийн санхүүжилтийг хангалттай хэмжээнд хүргэх, үүний тулд санхүүжилт, чиг үүргийг хуульчлан тодорхойлох шаардлагатай. Мөн олон талын оролцоот үйл явцын удирдлага, манлайллыг Засгийн газар, иргэний нийгэм хуваан, оролцооны тодорхой журмуудыг баримтлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Минимум шаардлагуудыг даган мөрдөх**

Хараат бус тайлагналын механизмын зүгээс процедурын хяналт хийх зорилгоор НЗТ-ийн Оролцоо, хамтран боловсруулах стандартад заасан минимум шаардлагуудыг улс орнууд хангасан эсэх үнэлгээ хийдэг.<sup>12</sup> Хамтран боловсруулах үйл явцын үеэр Монгол улс нь НЗТ-ийн тогтсон үйл явцыг зөрчсөн үйл ажиллагааг явуулсан.<sup>13</sup> Хэрэгжүүлэгч улс нь НЗТ-ийн үйл явцыг баримталж буй эсэх дээр “Ахиц гарч буй” гэсэн түвшнийг доор заасан буй хоёр минимум стандарт дээр хангасан байх шаардлагатай.

Үзүүлэлт:

- Ногоон = Стандартыг хангасан
- Шар = Ахиц гарч буй (шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлсэн ч стандартыг хангаагүй)
- Улаан = Үйл ажиллагаа явагдаж буй баримт нотолгоо байхгүй.

Хэрэгжилтийн хугацаанд НЗТ-ийн процессын дагуу үйл ажиллагаа явуулсан эсэх?	
<p>Засгийн газар нь НЗТ-ийн мэдээллийн санг олон нийтэд нээлттэйгээр <a href="https://www.irmn-tur.mn/mn/blog/ogp">irmn-tur.mn/mn/blog/ogp</a> портал дээр бүрдүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийн дийлэнх хугацаанд энэхүү мэдээллийн санд ямар нэгэн шинэчлэл хийгдээгүй. Гэсэн ч 2023 оны 3 дугаар сараас ХЭҮК түншлэлийг хариуцах болсноор илүү ойр давтамжтайгаар шинэчлэх болсон. 2023 оны 8 дугаар сарын 31-нд Засгийн газраас үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайланг бэлтгэн гаргасан.<sup>14</sup></p>	Шар
<p>Засгийн газар нь 2023 оны 7 дугаар сарын 4 болон 8 дугаар сарын 29-ны өдрүүдэд оролцогч талуудын уулзалт зохион байгуулж, үүнд Үндэсний зөвлөл дэх Засгийн газар болон иргэний нийгмийн төлөөлөл оролцсон.<sup>15</sup> Засгийн газрын зүгээс үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийг өгч, 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдөр бэлтгэн гаргасан өөрийн үнэлгээний тайланд саналаа өгөхийг иргэний нийгмийн төлөөллөөс хүссэн.<sup>16</sup> Тухайн хурлуудаар үндэсний үйл ажиллагааны тавдугаар төлөвлөгөөг хамтран боловсруулах бэлтгэл ажлын талаар хэлэлцсэн.<sup>17</sup></p>	Шар

<sup>1</sup> Б.Болорсайхан, Д.Номинчимэг (Хүний эрхийн үндэсний комисс), ХБТМ-ын асуумж, 2023 оны 7 сарын 19.

<sup>2</sup> Дараахыг үзнэ үү: “ХБТМ Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ: Монгол улс 2021–2023,” Нээлттэй засгийн түншлэл, 2022 оны 7 дугаар сарын 21, [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/07/Mongolia\\_2021-2023\\_Action-Plan-Review\\_EN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/07/Mongolia_2021-2023_Action-Plan-Review_EN.pdf), 4–5.

<sup>3</sup> “ХБТМ Монгол улсын хэрэгжилтийн төгсгөл хугацааны тайлан 2016–2018,” Нээлттэй засгийн түншлэл, 2020 оны 8 дугаар сарын 20, [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2020/08/Mongolia\\_End-of-Term\\_Report\\_2016-2018\\_EN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2020/08/Mongolia_End-of-Term_Report_2016-2018_EN.pdf); 3; “ХБТМ Монгол улс Дизайн төлөвлөлтийн тайлан 2019–2021,” Нээлттэй засгийн түншлэл, 2021 оны 11 дүгээр сарын 3, <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-design-report-2019-2021>, 12; “ХБТМ Монгол улс дунд үеийн үр дүнгийн тайлан 2019–2021,” Нээлттэй засгийн түншлэл, 2022 оны 2 дугаар сарын 16, [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/02/Mongolia\\_Transitional-Results-Report\\_2019-2021\\_EN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/02/Mongolia_Transitional-Results-Report_2019-2021_EN.pdf), 13.

<sup>4</sup> “Монгол улс – Хяналтад хамруулах тухай албан тоот (2021 оны 9 дүгээр сар),” Нээлттэй засгийн түншлэл, 2021 оны 9 дүгээр сарын 13, [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2021/09/Mongolia\\_Contrary-to-Process\\_20210909.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2021/09/Mongolia_Contrary-to-Process_20210909.pdf); “Монгол улс – Үйл явцыг зөрчиж буй мэдэгдсэн албан бичиг (2022 оны 2 дугаар сар),” Нээлттэй засгийн түншлэл, 2022 оны 2 дугаар сарын 23, [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/02/Mongolia\\_Contrary-to-Process-Letter\\_February2022.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/02/Mongolia_Contrary-to-Process-Letter_February2022.pdf).

<sup>5</sup> “ХБТМ Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ: Монгол улс 2021–2023,” Нээлттэй засгийн түншлэл, 2022 оны 7 дугаар сарын 21, [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/07/Mongolia\\_2021-2023\\_Action-Plan-Review\\_EN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/07/Mongolia_2021-2023_Action-Plan-Review_EN.pdf), 4.

<sup>6</sup> “Монгол улс – Хяналтад хамруулах тухай албан тоот (2021 оны 9 дүгээр сар)” Нээлттэй засгийн түншлэл.

<sup>7</sup> Г.Ундрал (Ардчиллын боловсрол төв), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2022 оны 2 дугаар сарын 16.

<sup>8</sup> Н.Баярсайхан (Ил хязгааргүй алхам ТББ), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2022 оны 2 дугаар сарын 14.

<sup>9</sup> Б.Болорсайхан, Д.Номинчимэг (Хүний эрхийн үндэсний комисс), ХБТМ-ын асуумж.

<sup>10</sup> “Засгийн газрын 103 дугаар тогтоол (2023 оны 3 дугаар сарын 22),” Монгол улсын Засгийн газар, 2023 оны 3 дугаар сарын 22, <https://www.irmn-tur.mn/file/download/33>.

---

<sup>11</sup> “НЗТ-ийн Олон талын оролцоот форум зохион байгуулагдлаа,” НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 2023 оны 7 дугаар сарын 4, <http://www.irgen-tur.mn/en/blog/ogp/single/195>; “Олон талын төлөөлөл НЗТ-ийн дугуй ширээний үүлзалтад оролцлоо,” НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 2023 оны 7 дугаар сарын 4, <http://www.irgen-tur.mn/en/blog/ogp/single/197>; “НЗТ-ийн Үндэсний зөвлөлийн 2 дугаар хуралдаан боллоо,” НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 2023 оны 8 дугаар сарын 29, <https://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/198>.

<sup>12</sup> Цаашид ХБТМ-ийн зүгээс хийх үнэлгээ нь 2022 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон НЗТ-ийн Хамтран боловсруулах, оролцооны шинэчилсэн стандартын дагуу хийгдэх болохыг анхаарна уу. Дараахыг үзнэ үү: “НЗТ-ийн Хамтран боловсруулах, оролцооны стандарт,” Нээлттэй засгийн түншлэл, 2021 оны 11 дүгээр сарын 24, <https://www.opengovpartnership.org/ogp-participation-co-creation-standards>.

<sup>13</sup> “ХБТМ Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ: Монгол улс 2021–2023,” Нээлттэй засгийн түншлэл, 20–21.

<sup>14</sup> “Монгол улсын Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан 2021–2023,” Монгол улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 2023 оны 8 дугаар сарын 31, <https://irgen-tur.mn/file/download/37>.

<sup>15</sup> “НЗТ-ийн Олон талын оролцоот форум зохион байгуулагдлаа,” НЗТ-ийн Үндэсний зөвлөл.

<sup>16</sup> “НЗТ-ийн Үндэсний зөвлөлийн 2 дугаар хуралдаан боллоо,” НЗТ-ийн Үндэсний зөвлөл.

<sup>17</sup> “Олон талын төлөөлөл НЗТ-ийн дугуй ширээний үүлзалтад оролцлоо,” НЗТ-ийн Үндэсний зөвлөл.

## Бүлэг IV. Арга зүй, ХБТМ-ын шалгуурууд

Энэхүү тайлан нь (i) үүрэг амлалтын хэрэгжилтийн түвшин, (ii) үр дүнтэй эсвэл хэрэгжилтийн хугацаанд томоохон хэмжээний үр дүн гаргах нь тогтоогдож буй, өндөр түвшинд хэрэгжсэн үүрэг амлалтуудаас гарсан эрт үеийн үр дүн болон (iii) үйл ажиллагааны төлөвлөгөөний мөчлөгийн хугацаан дахь оролцоо болон хамтран боловсруулах үйл явц зэрэгт үнэлгээ хийх замаар гишүүн орнуудын хариуцлагатай (эгэх хариуцлага) байдал, суралцах үйл явцад дэмжлэг үзүүлдэг. Хараат буй тайлагналын механизм нь үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний жилээс эхлэн судалгааны төлөвлөгөө боловсруулж, анхдагч баримт бичгийн судалгаа хийж, тухайн улсын НЗТ-ийн мэдээллийн сангаас авсан баримт нотолгоог нягтлан баталгаажуулах зэрэг үйл ажиллагааг эхлүүлсэн.<sup>1</sup>

2022 онд НЗТ нь 2023- 2028 онд баримтлах шинэ стратегийг хамтран гаргах хүрээнд зөвлөлдөх үйл ажиллагааг эхлүүлсэн.<sup>2</sup> Хараат бус тайлагналын механизм нь энэхүү стратеги эцэслэгдсэний дараагаар өөрийн бүтээгдэхүүн, үр дүн, үзүүлэлтүүд зэргийг эргэн харж, өөрчлөлт оруулна. Тэр хүртэл Үр дүнгийн тайлангийн хүрээнд, Хараат бус тайлагналын механизмын тайлангуудад өмнөхийн ижил үзүүлэлтүүдээр үргэлжлүүлэн үнэлгээ хийнэ:

### Бүрэн дуусгасан байдал

ХБТМ нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг амлалт нэг бүрээр, үүнд Үйл ажиллагааны төлөвлөгөөний хяналтын тайланд бүлэглэсэн үүргүүдийн хэрэгжилтийн түвшинд үнэлгээ хийдэг.<sup>3</sup> Үүрэг амлалт нэг бүрийн бүрэн дуусгасан түвшнийг доорх дурдсаны аль нэгээр нь үнэлдэг:

- *Баримт нотолгоо байхгүй*
- *Эхлүүлээгүй*
- *Хязгаарлагдмал*
- *Тодорхой хэмжээнд*
- *Бүрэн*

### Эрт үеийн үр дүн

Хараат бус тайлагналын механизм нь үүрэг амлалт эсвэл нээлттэй засгийн үүднээс тодорхойлон бүлэглэсэн (кластер) үүрэг амлалтуудын хэрэгжилтийн үр дүнгийн түвшин, бүрэн хэрэгжсэн түвшин эсвэл эрт үеийн үр дүнг гаргаж буй баримт нотолгоо буй эсэхийг (доор тодорхойлсон) үнэлэн дүгнэдэг. Тус механизм нь үүрэг амлалт эсвэл кластер зорилтуудын хүлээгдэж буй зорилт, эдгээрийн хэрэгжих улс орны онцлог нөхцөл байдал, бодлогын тусгайлсан чиглэл, тайлагнаж буй өөрчлөлт зэргийг хэрэгжиж эхлэхээс өмнө судалдаг. Кластер болгон бүлэглэсэн үүрэг амлалтуудын хувьд үр дүнгийн түвшнийг дагнасан үүрэг амлалтын бус харин кластерын түвшинд үнэлдэг.

Монгол улсын 2021- 2023 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийсэн үнэлгээгээр үүрэг амлалт 2 болон 8-ыг нэгтгэн бүлэглэсэн ба эдгээр нь мэдээллийн ил тод байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой эрх зүйн орчныг тусгасан үүрэг амлалтууд байсан. Дизайны хувьд үүрэг амлалт 2 болон 8 дээр туссан үйл ажиллагаанд хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн ба үүнд Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан албаны нууцын жагсаалтыг тодорхойлох журмыг боловсронгуй болгохоор төлөвлөжээ. Гэвч эдгээр үүрэг амлалтуудын хэрэгжилт нь ялгаатай, хамтын үйл ажиллагаа нь бүрэн хэрэгжээгүй байна. Тиймээс Үр дүнгийн тайлан нь эдгээр үүрэг

амлалтуудыг кластер байдлаар үнэлэлгүйгээр, нэг бүрчлэн эрт үеийн үр дүнг үнэлэн гаргасан.

Эрт үеийн үр дүнгийн үзүүлэлтээр үр дүнгийн гурван түвшнийг тогтоон гаргадаг:

- **Мэдэгдэхүйц үр дүн гараагүй:** Цуглуулсан баримт нотолгоонд (баримт бичгийн судалгаа, ярилцлага гэх мэт) дурдсанаас үзвэл нээлттэй засгийн чиглэлийн үүрэг амлалт/ кластер үүрэг амлалтууд нь маш үр дүнтэй эсвэл үр дүн гараагүй байна. Хэрэгжилтийн хугацаанд хойшлуулан хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон эдгээрийн үр дүнд (хэрэв байгаа бол) үнэлгээ хийсний дараа Хараат бус тайлагналын механизм нь дараах чиглэлд ямар нэгэн бодит өөрчлөлт гарсан хэмээн үзэхгүй байна:
  - Хамаарах бодлогын чиглэл эсвэл төрийн салбар доторх арга ажиллагаа, бодлого эсвэл институцыг сайжруулах чиглэлд, эсвэл
  - Төр болон иргэний хооронд итгэлцэл бүрдүүлэх боломжит орчныг сайжруулах чиглэлд.
- **Бага хэмжээний үр дүн гарсан:** Цуглуулсан баримт нотолгоонд (баримт бичгийг судалгаа, ярилцлага гэх мэт) үндэслэн үзвэл нээлттэй засгийн чиглэлийн үүрэг амлалт/ кластер үүрэг амлалтуудын хэрэгжилт нь эерэг өөрчлөлтөд хөтөлжээ. Хэрэгжилтийн хугацаанд хойшлуулан хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон эдгээрийн үр дүнд үнэлгээ хийсний дараа Хараат бус тайлагналын механизм нь дараах чиглэлд тодорхой хэмжээний өөрчлөлт гарсан хэмээн үзэж байна:
  - Хамаарах бодлогын чиглэл эсвэл төрийн салбар доторх арга ажиллагаа, бодлого эсвэл институцыг сайжруулах чиглэлд, эсвэл
  - Төр болон иргэний хооронд итгэлцэл бүрдүүлэх боломжит орчныг сайжруулах чиглэлд.
- **Өндөр үр дүн гарсан:** Цуглуулсан баримт нотолгоонд (баримт бичгийг судалгаа, ярилцлага гэх мэт) үндэслэн үзвэл нээлттэй засгийн чиглэлийн үүрэг амлалт/ кластер үүрэг амлалтуудын хэрэгжилт нь өндөр хэмжээний эерэг өөрчлөлтөд хөтөлжээ. Хэрэгжилтийн хугацаанд хойшлуулан хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон эдгээрийн үр дүнд үнэлгээ хийсний дараа Хараат бус тайлагналын механизм нь дараах чиглэлд өндөр өөрчлөлт гарсан хэмээн үзэж байна:
  - Хамаарах бодлогын чиглэл эсвэл төрийн салбар доторх арга ажиллагаа, бодлого эсвэл институцыг сайжруулах чиглэлд, эсвэл
  - Төр болон иргэний хооронд итгэлцэл бүрдүүлэх боломжит орчныг сайжруулах чиглэлд.

Томоохон хэмжээний эерэг үр дүн нь (дээр тодорхойлсон) цаашид тогтвортой үргэлжилнэ гэсэн эерэг хүлээлтийг үүсгэж байна.

Энэхүү тайланг ХБТМ-ын зүгээс Равио Патратай (Ravio Patro) хамтран бэлтгэж, хөндлөнгийн зөвлөх Брендан Халларон (Brendan Halloran) хянан тохиолдуулсан. ХБТМ-ын арга зүй, гаргаж буй бүтээгдэхүүний чанар, хяналт үнэлгээний үйл явцыг ХБТМ-ын Олон улсын экспертүүдийн панел (IEP) хянадаг. Одоо тус панел нь дараах бүрэлдэхүүнтэй ажилладаг:

- Снжезана Бокулич (Snjezana Bokulic)
- Цезар Круз- Рубио (Cesar Cruz-Rubio)
- Мари Франколи (Mary Francoli)
- Маха Жвейд (Maha Jweied)
- Рокио Морено Лопез (Rocio Moreno Lopez)

Энэхүү хяналт үнэлгээний үйл явц, үүнд анхны төсөл дээр хүлээн авсан саналуудыг тусгах үйл явцыг Процедурын гарын авлагын<sup>4</sup> Бүлэг III болон Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ 2021- 2023 дээр дэлгэрэнгүй тусгасан. Дэлгэрэнгүй мэдээллийг НЗТ-ийн вэбсайт дээрх “ХБТМ-ын Хяналт” (IRM Overview) хэсгээс үзнэ үү.<sup>5</sup> ХБТМ болон НЗТ-ийн үг хэллэгийн тайлбарыг НЗТ-ийн вэбсайт дээрээс үзэж болно.<sup>6</sup>

<sup>1</sup> “Монгол улсын НЗТ-ийн мэдээллийн сан,” Монгол улсын Засгийн газар, 2023 оны 9 дүгээр сарын 27-ны байдлаар, <https://irgen-tur.mn/mn/blog/ogp>.

<sup>2</sup> Дараахыг үзнэ үү. “Creating OGP’s Future Together: Strategic Planning 2023–2028,” Open Government Partnership, <https://www.opengovpartnership.org/creating-ogps-future-together>. (НЗТ-ийн ирээдүйг хамтдаа бүтээх нь: Стратеги төлөвлөгөө 2023- 2028, НЗТ)

<sup>3</sup> ХБТМ нь нэгэн ижил бодлогын зорилгод чиглэсэн үүрэг амлалтуудыг Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ хийхдээ бүлэглэн кластер болгон авч үздэг. Энэ тохиолдолд ХБТМ нь кластерын түвшинд “Үр дүн гаргах боломж” болон “Эрт үеийн үр дүнг” үнэлэн гаргадаг. Бүрэн хэрэгжиж дууссан түвшнийг үүрэг амлалт нэг бүрийн түвшинд үнэлнэ. ХБТМ нь үүрэг амлалтуудыг хэрхэн бүлэглэдэг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Арга зүйн гарын авлагын Бүлэг IV болон Үйл ажиллагааны төлөвлөгөөнд ашигласан ХБТМ-ын Шалгуур үзүүлэлтүүд дээр үзнэ үү.

<sup>4</sup> “ХБТМ-ын Процедурын гарын авлага (IRM Procedures Manual),” Нээлттэй засгийн түншлэл, 2017 оны 9 дүгээр сарын 16, <https://www.opengovpartnership.org/documents/irm-procedures-manual>.

<sup>5</sup> “ХБТМ-ын Хяналт (IRM Overview),” Нээлттэй засгийн түншлэл,” <https://www.opengovpartnership.org/irm-guidance-overview>.

<sup>6</sup> “НЗТ-ийн толь бичиг (OGP Glossary),” Нээлттэй засгийн түншлэл,” <https://www.opengovpartnership.org/glossary>.



## Хавсралт I. Үүрэг амлалтуудад хамаарах өгөгдөл мэдээлэл<sup>1</sup>

### Үүрэг амлалт 1: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал

- |  |   |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой эсэх:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Тийм</li> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Өндөр</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан байдал:</b> Хязгаарлагдмал</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Мэдэгдэхүйц үр дүн байхгүй</li> </ul> |
|--|---|

Хэрэгжилтийн хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь ОУИТБС-ын хүрээнд үүсгэсэн өгөгдлийн санг ашиглан шинээр Эрдэс баялгийн салбарын мэдээллийн санг нээлттэй өгөгдлийн форматаар Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр байгуулсан.<sup>2</sup> Гэвч иргэний нийгмийн оролцогч талуудын зүгээс ОУИТБС-ын мэдээллийн санг илүү иж бүрэн хэмээн үзэж, тэдгээр өгөгдлийн сангуудыг нийлүүлэхийг зөвлөж байна.<sup>3</sup> Энэхүү үүрэг амлалтын гол зорилт болох Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл (өмнө нь Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн төсөл хэмээн нэрлэгдэж байсан) нь хэрэгжилтийн хугацаанд эцэслэн батлагдаагүй байна. УУХҮЯ-ны зүгээс хуулийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлж, олон нийтийн хэлэлцүүлгийг хийж, улмаар ХЗДХЯ нь төсөлд ус, ойн нөөц, ан агнуурыг мөн хамруулах чиглэлд ажилласан.<sup>4</sup> Сангийн яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төлөөлөл бүхий хуулийн төслийн ажлын хэсэг энэхүү төслийг эцэслэн бэлтгэн гаргасан. УИХ-ын Даргын зүгээс энэхүү хуулийг дэмжиж буйгаа олон нийтэд хандан илэрхийлсэн ч Засгийн газрын зүгээс эцэслэн батлах үйл явц удаашралтай байна.<sup>5</sup> Иргэний нийгмийн төлөөллийн зүгээс энэхүү хуулийг батлахгүй бол цаашид олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа нь гадаадын санхүүжилтээс хамааралтай хэвээр байх болно хэмээн үзэж байна.<sup>6</sup> Хуулийн төсөлд Засгийн газраас тусгайлан төсөв хуваарилах үүрэг тусгагдаагүй ч тус хууль батлагдсанаар тодорхой төсөв хөрөнгө хуваарилах, олон улсаас дэмжлэг туслалцааг илүү тогтвортой байдлаар татах боломжтой болно гэж иргэний нийгмийн зүгээс итгэж байна.<sup>7</sup> 2013- 2019 онуудад гарсан 12.8 тэрбум ам.долларын үнэ бүхий нүүрсний хулгайн тухай мэдээлэл 2022 онд нийтэд хүрснээр олон хоногийн туршид эсэргүүцлийн арга хэмжээ өрнөж буй Монгол улсад энэхүү шинэтгэлийн үйл ажиллагаа нь Монгол улсад авлигатай тэмцэхэд чухал үүрэгтэй юм.<sup>8</sup>

### Үүрэг амлалт 2: Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох

- |   |  |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой эсэх:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Тийм</li> <li>• Энэхүү үүрэг амлалтыг дараах байдлаар бүлэглэсэн: Мэдээлэл авах эрх чөлөө, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан байдал:</b> Дорвитой</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Дунд хэмжээнд</li> </ul> |
|---|--|

<p>чиглэлийн хууль тогтоомж (Үүрэг амлалт 2 болон 8)</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Өндөр/ дорвитой</li> </ul>	
<p>Энэ үүрэг амлалтыг Хэсэг II дээр багтаан үнэлсэн.</p>	
<p><b>Үүрэг амлалт 3: Төрийн худалдан авах ажиллагаа дахь олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх</b></p>	
<ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой юу:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Тийм</li> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Өндөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан байдал:</b> Өндөр/их</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Өндөр</li> </ul>
<p>Энэ үүрэг амлалтыг Хэсэг II дээр үнэлсэн.</p>	
<p><b>Үүрэг амлалт 4: Иргэний орон зайг хамгаалсан хууль тогтоомжийг батлан гаргах</b></p>	
<ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой юу:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Тийм</li> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Дунд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан байдал:</b> Хязгаарлагдмал</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Мэдэгдэхүйц үр дүн байхгүй</li> </ul>
<p>Энэхүү үүрэг амлалт нь иргэний орон зайг хамгаалах зохицуулалтыг нэвтрүүлэхэд чиглэсэн ч ямар нэгэн эерэг үр дүнг хараахан гаргаагүй. ХЗДХЯ-ны зүгээс Холбооны эрх зүйн байдлын болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг боловсруулан, 2021 оны 11 дүгээр сард УИХ-д өргөн мэдүүлсэн. НЗТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийн төгсгөл үеийн байдлаар энэ амлалт нь 2022 оны 1 дүгээр сард УИХ дээр явагдсан урьдчилсан хэлэлцүүлгээс цааш ахиц гаргаагүй хэвээр байна.<sup>9</sup> Засгийн газрын зүгээс энэхүү хуулийн төслүүдийг иргэний нийгмийг бэхжүүлэх арга хэмжээ хэмээн тайлбарлаж буй бол ИНБ-уудын зүгээс төсөлд тусгасан ИНБ-уудыг бүртгэх хүндрэлтэй, зардал өндөртэй үйл явц дээр ихээхэн санаа зовниж байна. Тэдний хувьд энэхүү бүртгэлийн шаардлага нь жижиг хэмжээний, санхүүжилт дутмаг ИНБ-уудын хувьд хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад ихээхэн саад учруулна хэмээн үзэж буй юм.<sup>10</sup> Үүрэг амлалтад тусгагдсан бусад үйл ажиллагааны хувьд ИНБ-уудыг бүртгэх үйл явцыг хялбаршуулсан эсвэл УБЕГ-ын ажиллуулж буй <a href="https://opendata.burtgel.gov.mn">opendata.burtgel.gov.mn</a> портал дээр онлайнаар бүртгүүлэх боломжийг бүрдүүлсэн талаарх баримт нотолгоо байхгүй.<sup>11</sup> Эцэст нь ИНБ-уултай хамтран ажиллах түншлэлийн талаарх бодлогыг боловсруулах үйл явцад Ерөнхий сайдын зүгээс 2023 оны 4 дүгээр сард дэмжлэг үзүүлж байсан ч мухардалд оржээ.<sup>12</sup> ХЗДХЯ-ны үзэж буйгаар төрийн зүгээс ИНБ-уудад тавих хяналт, үүний хамрах хүрээний талаар талууд нийтлэг ойлголцолд хүрч чадаагүй байна.<sup>13</sup> Нийтэд нь авч үзвэл үүрэг амлалт нь</p>	

ирээдүйтэй, хэрэгжихүйцээр төлөвлөгдсөн ч хэрэгжилтийн явцад Засгийн газар болон иргэний нийгмийн хамтын оролцоо тасалдах асуудалтай тулсан байна.

**Үүрэг амлалт 5: Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд олон нийтийн оролцоог хангах**

- |   |   |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой эсэх:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Тийм</li> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Дунд</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан байдал:</b> Хязгаарлагдмал</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Мэдэгдэхүйц үр дүн байхгүй</li> </ul> |
|---|---|

Энэхүү үүрэг амлалт нь Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилготой. Тухайн хууль нэг бүр дээр тухайн үүрэг амлалт нь хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд олон нийтийн оролцоог ханган, улмаар цаашид хийгдэх шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг мэдээллээр ханган өгөхөөр төлөвлөсөн. УИХ нь Нийтийн сонсголын тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг 2021 оны 12 дугаар сарын 24<sup>14</sup> (үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ирүүлэхээс нэг долоо хоногийн өмнө) болон 2022 оны 12 дугаар сарын 23-нд тус тус батлан гаргасан.<sup>15</sup> Гэсэн хэдий ч эдгээр хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангасан гэсэн ямар нэгэн нотолгоо байхгүй.<sup>16</sup> Хэрэгжилтийн төгсгөл үед гэхэд Хог хаягдлын тухай хуулийг сайжруулах чиглэлээр ямар нэгэн ахиц гараагүй байна. Нийтэд нь авч үзвэл энэхүү үүрэг амлалт нь дээр дурдсан хуулийг батлах бус харин өөрөөр тодорхойлсон гол зорилго болох хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд олон нийтийн оролцоулахад эрт үеийн/ урьдчилсан үр дүнг гаргаагүй байна. Нийтийн сонсголын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөс үүдсэн эрт үеийн үр дүнгүүдийн үнэлгээг Үүрэг амлалт 2-ын хүрээнд багтаан үнэлсэн (Хэсэг II дээр үзнэ үү).

**Үүрэг амлалт 6: Төсвийн хөрөнгө оруулалт, улсын төсөвт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх**

- |   |  |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой эсэх:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Тийм</li> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Дунд</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан байдал:</b> Өндөр</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Мэдэгдэхүйц үр дүн байхгүй</li> </ul> |
|---|--|

Улсын төсөв, хөрөнгө оруулалт дахь олон нийтийн оролцоог сайжруулах үүрэг амлалтуудын ихэнх төлөвлөгдсөн үйл ажиллагааг Сангийн яаман дээр хэрэгжиж буй төслийн хүрээнд хийсэн байна. Шилэн дансны порталын хувьд<sup>17</sup> 2022 онд хэлэлцэн батлах хууль тогтоомжийн хуваарьт Шилэн дансны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн багтаахаар төлөвлөсөн ч энэхүү нэмэлт өөрчлөлтийн төслийг УИХ-аар

хэлэлцүүлэхээр өргөн бариагүй байна.<sup>18</sup> Энэ үүрэг амлалтын хүрээнд 2023 оны 1 дүгээр сард порталын чанарыг сайжруулсан ч өмнөх жилүүдийн төсвийн мэдээлэл тус порталаас устгагджээ.<sup>19</sup> Олон улсын төсвийн түншлэлийн (International Budget Partnership) зүгээс үзэхдээ төсвийн баримт бичгүүдэд багтсан буй мэдээллүүд нь зөв зохистой бус, харилцан уялдаагүй буй нь иргэдийн зүгээс Засгийн газрын хөтөлбөрүүдэд хяналт тавихад хүндрэл үүсгэж байна. Порталын оролцооны суваг байхгүй нь энэхүү нөхцөл байдлыг улам нэмэгдүүлжээ.<sup>20</sup> Түүнчлэн 2022 оны Төсвийн тухай хууль<sup>21</sup> болон 2023 оны санхүүгийн жилийн төсвийн төлөвлөлтөд<sup>22</sup> өмнө нь улсын төсөвт тусгагддаггүй байсан төсвийн санхүүжилт бүхий төслүүдийн мэдээллийг нэмж оруулахаар өөрчилжээ. Нэмэлт өөрчлөлтийн хүрээнд олон нийтийн оролцоотой холбоотой заалтуудыг оруулсан ч эдгээрийг төсвийн хуанлийн хүрээнд бодитоор хэрэгжихгүй буй нь 2023 оны 10 дугаар сарын байдлаар тогтоогдож байна.<sup>23</sup> Иргэдийн төсвийн порталын хүрээнд төлөвлөсөн 2 үйл ажиллагааны хүрээнд<sup>24</sup> тус яам нь Иргэний оролцооны болон Санал, хэлэлцүүлгийн дэд цэсийг<sup>25</sup> нэмэлтээр оруулсан ч иргэдээс ирүүлсэн саналыг төслийн шийдвэр гаргалтад хэрхэн тусгасан талаарх эгэх холбоог орхигдуулсан байна.<sup>26</sup> Мөн яамны зүгээс [publicinvestment.gov.mn](http://publicinvestment.gov.mn) порталыг төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор хөгжүүлжээ. Гэвч тус портал нь 2023 оноос эхлэн хийгдсэн хөрөнгө оруулалтыг хамарсан тул өмнөх жилүүдийн мэдээллийн хүртээмжийг хязгаарлажээ.<sup>27</sup> 2024 оны төсвийн жилийн төлөвлөлтийн явцад яам нь дүүрэг, хороо, нийслэл, аймгийн хэмжээнд хийгдэх шаардлагатай хөрөнгө оруулалтын төслүүдэд иргэд саналаа өгөх боломжийг бүрдүүлсэн.<sup>28</sup> ХБТМ нь энэхүү санал нь төслийг сонгоход хэрхэн нөлөөлсөн талаар ямар нэгэн баримт нотолгоог олоогүй.

Үндсэндээ энэхүү үүрэг амлалтын хүрээнд төрийг нээлттэй болгох чиглэлээр тэмдэглүүштэй амжилт гаргаагүй байна. Олон нийтийн оролцооны механизм нь шийдвэр гаргалтыг мэдээллээр ханган өгөхтэй уялдаж холбогдоогүй, төсвийн чиглэлээр олон нийтийн зүгээс гаргасан саналуудад Засгийн газрын зүгээс үндэслэл бүхий хариу өгөх нь хязгаарлагдмал, төсвийн төлөвлөлтийн шатнаас бусдаар иргэд саналаа гаргах боломж хаалттай хэвээр байна.<sup>29</sup> Төсвийн мэдээллийн ил тод байдлын хувьд нөхцөл байдал тодорхой хэмжээнд сайжирсан ч өмнөх жилүүдийн мэдээлэл хаалттай буй тул ач холбогдол нь буурч байна. Цаашид Засгийн газар нь олон нийтийн зөвлөлдөх механизмын үүрэг ролийг илүү тодорхой болгох, үүнд иргэдээс ирүүлсэн саналыг цаашдын шийдвэр гаргалтад хэрхэн тусгаж байхыг тусгайлан зааж өгөх шаардлагатай байна. Түүнчлэн төслийн зарцуулалт/ хэрэгжилт болон хяналт/ үнэлгээний шатанд ил тод байдлыг илүүтэйгээр хангах зорилгод шаардлагатай хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг хийх үйл ажиллагааг эрэмбэлэн гаргах нь чухал. Мөн олон төрлийн порталуудыг нэг платформд нэгтгэснээр төсвийн төлөвлөлт, гүйцэтгэх болон аудитын шатанд иргэд төслийн хөрөнгийн урсгалыг хянах боломжийг хангах нь зүйтэй. Үүний тулд Засгийн газраас иргэдэд зориулсан төсвийн иж бүрэн байдлыг сайжруулах, төлөвлөлтөөс эхлээд аудит хүртэлх бүхий л мөчлөгийн хүрээнд өгөгдөл мэдээллийн нийцтэй байдлыг баталгаажуулах шаардлагатай.<sup>30</sup>

## Үүрэг амлалт 7: Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын ил тод байдал

<ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой эсэх:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Үгүй</li> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Дунд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан байдал:</b> Хязгаарлагдмал</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Мэдэгдэхүйц үр дүн байхгүй</li> </ul>
<p>Энэхүү Үүрэг амлалтын хүрээнд Эрүүл мэндийн яамны зүгээс түгээмэл хэрэглэдэг эмийн үнэд үнэлгээ хийж, салбар дундын ажлын хэсэг байгуулан хамаарах дүрэм, журмуудын талаар хэлэлцэн, өгөгдөл мэдээллийг нэгтгэн уялдуулах чиглэлээр хамтын ажиллагааг сайжруулан ажиллаж байна.<sup>31</sup> Тус Ажлын хэсэг нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийг боловсруулж, үүнд эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн дээд тааз, импортын механизмыг тусгажээ. Гэвч энэхүү үйл явцад иргэний нийгмийн төлөөллийг оролцуулаагүй, олон нийтийн зүгээс санал өгөх боломжийг нээн өгөөгүй байна.<sup>32</sup> Нийтэд нь үзвэл КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээнд төвлөрч ирсний улмаас тус яамны энэ чиглэлээрх үйл ажиллагааг удааширч, энэхүү үүрэг амлалтыг ханган биелүүлэх чиглэлээр ахиц дэвшил гаргах нь саарчээ. Энэхүү үүрэг амлалт нь нээлттэй засгийн зорилтод чиглэн төлөвлөгдөөгүй тул төрийг нээлттэй болгох чиглэлд боломжит үр дүнг үзүүлээгүй.</p>	
<p><b>Үүрэг амлалт 8: Хэвлэлийн эрх чөлөөг хангасан эрх зүйн орчныг бүрдүүлэх</b></p>	
<ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой эсэх:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Тийм</li> <li>• Энэхүү үүргийг дараах байдлаар бүлэглэсэн: Мэдээлэл авах болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж (Үүрэг амлалт 2 болон 8)</li> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Өндөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан байдал:</b> Эхлүүлээгүй</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Мэдэгдэхүйц үр дүн байхгүй</li> </ul>
<p>Энэхүү үүрэг амлалтын хүрээнд Төрийн болон албаны нууцын тухай хууль, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан сайжруулах олон талын оролцоот үйл явцыг хангахад чиглэсэн. Үүрэг амлалтын хэрэгжилтэд төлөвлөгөөний нийт хугацаанд ямар нэгэн ахиц гараагүй болох нь Засгийн газрын өөрийн үнэлгээний тайлан, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн зүгээс өгч буй тайлбараас тодорхой харагдаж байна. Хэрэгжилтийн хугацаанаас өмнө буюу 2020 оны 3 дугаар сард эдгээр 3 хуулийн анхдагч үнэлгээг хийж гүйцэтгэсэн.<sup>33</sup> Үүний дараагаар 2020 оны 12 дугаар сард нэмэлт өөрчлөлтүүдийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан.<sup>34</sup> Төрийн болон албаны нууцын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хаалтай судалж буй үндэслэлээр ямар нэгэн ахиц дэвшил гараагүй.<sup>35</sup></p>	

### Үүрэг амлалт 9: Төрийн үйлчилгээг цахимжуулж, хүртээмжийг нэмэгдүүлэх

- |   |   |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> <li>• <b>Баталгаажуулан үнэлэх боломжтой эсэх:</b> Тийм</li> <li>• <b>Үүрэг амлалт нь нээлттэй засгийг бүрдүүлэх зорилготой юу?</b> Тийм</li> <li>• <b>Үр дүнд хүрэх боломж:</b> Дунд</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• <b>Бүрэн хэрэгжиж дууссан эсэх:</b> Бүрэн</li> <li>• <b>Эрт үеийн үр дүн:</b> Дунд хэмжээнд</li> </ul> |
|---|---|

Энэхүү Үүрэг амлалтад хийсэн үнэлгээг Хэсэг II дээр тусгасан.

#### <sup>1</sup> Редакцын тэмдэглэл:

1. Бүлэглэн кластер болгосон үүрэг амлалтуудын хувьд боломжит үр дүнгийн үнэлгээг нэг бүрийн бус харин кластерын түвшинд хийж гүйцэтгэсэн. Бүлэглэсэн үүрэг амлалтуудын хэрэгжилт нь ялгаатай байсан ч эрт үеийн үнэлгээ нь кластерын бус харин үүрэг амлалт нэг бүрийн түвшинд хийгдсэн (бүлэг IV. Арга зүй болон ХБТМ-ын Шалгуур үзүүлэлт дээр үзнэ үү).
  2. Үүрэг амлалтуудын богино нэршлийг тодорхой болгох үүднээс товчилсон байж болно. Үүрэг амлалтуудын бүрэн текстийг дараах холбоос дээр үзнэ үү: “Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө 2021–2023,” Монгол улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 2021 оны 12 дугаар сарын 31, <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2021-2023>.
  3. Үүрэг амлалтуудын дизайн үнэлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хэсгээс үзнэ үү: “ХБТМ Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ: Монгол улс 2021–2023,” Нээлттэй засгийн түншлэл, 2022 оны 7 дугаар сарын 21, <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-review-2021-2023>.
- <sup>2</sup> Ш.Цолмонтой (ОУИТБС-ын Ажлын алба) ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага. 2023 оны 10 дугаар сарын 5.
- <sup>3</sup> Д.Эрдэнэчимэгтэй (Нээлттэй нийгэм форум) ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага. 2023 оны 10 дугаар сарын 5.
- <sup>4</sup> Ш.Цолмонтой хийсэн ярилцлага.
- <sup>5</sup> Д.Эрдэнэчимэгтэй хийсэн ярилцлага.
- <sup>6</sup> Засгийн газраас ОУИТБС-ын Ажлын албаны цалин болон үйл ажиллагааны зардлуудын санхүүжүүлдэг бол олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төсөв нь олон улсын донор байгууллагуудаас хамааралтай, улсын төсөвт багахан хэмжээний хөрөнгө тусгадаг (Ш.Цолмонтой хийсэн ярилцлага).
- <sup>7</sup> Ш.Цолмон болон Д.Эрдэнэчимэг нартай хийсэн ярилцлага.
- <sup>8</sup> П. Мөнхчимэг, “Mongolians brave bitter cold to protest 'coal theft' corruption,” Reuters, 8 December 2022, <https://www.reuters.com/world/asia-pacific/mongolians-brave-bitter-cold-protest-coal-theft-corruption-2022-12-08>. (Монголчууд нүүрсний хулгайг эсэргүүцэж байна), Ройтерс, 2022 оны 12 дугаар сарын 8.
- <sup>9</sup> “Civic Freedom Monitor: Mongolia,” (Иргэний эрх чөлөөний хяналт: Монгол улс) Олон улсын ашгийн бус эрх зүйн төв, 2023 оны 8 дугаар сарын 9-нд шинэчилсэн хувилбар, <https://www.icnl.org/resources/civic-freedom-monitor/mongolia>.
- <sup>10</sup> Ш.Ариунаатай (Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо) ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2022 оны 2 дугаар сарын 17.
- <sup>11</sup> Порталыг 2021 оны 6 дугаар сарын 15 (Үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжиж эхлэхээс өмнө) болон 2023 оны 8 дугаар сарын 19-ны байдлаар харьцуулан ХБТМ нь үйл ажиллагааг бүрэн дуусгасан болохыг харуулах ямар нэгэн өөрчлөлтийг тодорхойлоогүй. Дараахыг үзнэ үү (2021 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар судлан гаргасан), “Улсын бүртгэлийн ерөнхий газар, 2023 оны 8 дугаар сарын 15-ны байдлаар, <http://web.archive.org/web/20210615211349/http://opendata.burtgel.gov.mn>.”
- <sup>12</sup> “Civic Freedom Monitor: Mongolia,” (Иргэний эрх чөлөөний хяналт: Монгол улс) Олон улсын ашгийн бус эрх зүйн төв.
- <sup>13</sup> “Албан тоот No. ХЭГ/721,” Хууль зүй, дотоод хэргийн яам, 2023 оны 3 дугаар сарын 30.
- <sup>14</sup> “Нийтийн сонголын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт,” Монгол улсын Засгийн газар, 2021 оны 12 дугаар сарын 24, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11225&type=2>.
- <sup>15</sup> Дараахыг үзнэ үү: “Захиргааны Ерөнхий Хуульд Нэмэлт, Өөрчлөлт Оруулах Тухай,” Монгол улсын Засгийн газар, 2023 оны 12 дугаар сарын 23 <https://www.parliament.mn/files/060227daa6fe46f69622ec44d59e4f32/?d=0>.
- <sup>16</sup> “Албан тоот No. ХЭГ/721,” Хууль зүй, дотоод хэргийн яам.
- <sup>17</sup> Дараах холбоосоор үзнэ үү: [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn).
- <sup>18</sup> Нээлттэй нийгэм форум, “НЗТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023” дээр өгсөн санал, НЗТ-ийн Үндэсний зөвлөл, 17–18.
- <sup>19</sup> Д.Эрдэнэчимэгтэй хийсэн ярилцлага.

- <sup>20</sup> Зауд Хасан болон Лилиана Зиединс (Олон улсын төсвийн түншлэл), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2023 оны 10 дугаар сарын 12.
- <sup>21</sup> Дараахыг үзнэ үү: “Монгол Улсын 2022 Оны Төсвийн Тухай Хуульд хийгдсэн нэмэлт өөрчлөлт”, Монгол улсын Засгийн газар, 2022 оны 4 дүгээр сарын 29, <https://www.parliament.mn/laws/904>.
- <sup>22</sup> Дараахыг үзнэ үү: “Монгол Улсын 2023 Оны Төсвийн Тухай,” Монгол улсын Засгийн газар, 2022 оны 11 дүгээр сарын 11, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16532001935011>.
- <sup>23</sup> Suad Hasan & Lilianna Ziedins (Олон улсын төсвийн түншлэл), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2023 оны 10 дугаар сарын 12.
- <sup>24</sup> Дараах холбоосоор үзнэ үү: <iltod.mof.gov.mn>.
- <sup>25</sup> Энэхүү төслийг Швейцарын хөгжлийн агентлаг болон Дэлхийн банкны Нийгмийн хариуцлагын олон улсын түншлэл (GPSA) төслөөс санхүүжүүлж, Дэлхийн зөн Монгол болон Глоб Интернейшнл байгууллага Сангийн яамтай хамтран хэрэгжүүлсэн. Дараахыг үзнэ үү: “Нийгмийн эгэх хариуцлагыг Монгол улсад төлөвшүүлэх нь 2 төсөл амжилттай хэрэгжлээ, Дэлхийн зөн Монгол, 2023 оны 6 дугаар сарын 9, <https://worldvision.mn/http-www-irgen-tur-mn-en>.
- <sup>26</sup> Д.Эрдэнэчимэгтэй хийсэн ярилцлага.
- <sup>27</sup> Нээлттэй нийгэм форум, “НЭТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023” дээр өгсөн санал, НЭТ-ийн Үндэсний зөвлөл, 22.
- <sup>28</sup> Санал хураалтыг Тогтвортой амьжиргаа төслийн 2 дугаар шатны хүрээнд хөгжүүлсэн, Дэлхийн банкны санхүүжилт бүхий Орон нутгийн хөгжлийн сангийн гар утасны аппликейшнээр дамжуулан хийдэг. Дараах хэсгийг үзнэ үү: “ОНХС-ийн цахим санал асуулга 6 дугаар сарын 25-нд дуусна,” <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/?p=27910>; “Монгол улс- Тогтвортой амьжиргаа төслийн 3 дугаар шатны санхүүжилт,” Дэлхийн банк, 2020 оны 4 дүгээр сарын 24, <https://www.worldbank.org/en/news/loans-credits/2020/04/24/mongolia-third-sustainable-livelihoods-project-additional-financing>.
- <sup>29</sup> Нээлттэй нийгэм форум, “НЭТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023” дээр өгсөн санал, НЭТ-ийн Үндэсний зөвлөл, 21–22.
- <sup>30</sup> Хасан болон Зиединс нартай хийсэн ярилцлага.
- <sup>31</sup> Албан тоот No. ХЭГ/721,” Эрүүл мэндийн яам, 2023 оны 3 дугаар сарын 30.
- <sup>32</sup> “Албан тоот No. ХЭГ/721,” Эрүүл мэндийн яам.
- <sup>33</sup> Монголын хэвлэлийн зөвлөл, “НЭТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023” дээр өгсөн санал, НЭТ-ийн Үндэсний зөвлөл, 2023 оны 8 дугаар сарын 31, <https://irgen-tur.mn/file/download/37>, 25.
- <sup>34</sup> Монголын хэвлэлийн зөвлөл, “НЭТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023” дээр өгсөн санал, НЭТ-ийн Үндэсний зөвлөл, 23.
- <sup>35</sup> Монголын хэвлэлийн зөвлөл, “НЭТ Монгол улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрийн үнэлгээний тайлан 2021–2023” дээр өгсөн санал, НЭТ-ийн Үндэсний зөвлөл, 26.